

# Элч Нарын Тунхаг

5-р хичээл

ЧУУЛГАН

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

### **ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ**

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

#### **Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.**

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.thirdmill.org](http://www.thirdmill.org) цахим хуудсаар зочлоорой.

# Элч нарын тунхаг

5-р хичээл

ЧУУЛГАН

## Гарчиг

<b>УДИРТГАЛ</b> .....	<b>1</b>
<b>ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛ</b> .....	<b>2</b>
Хуучин Гэрээ.....	3
Есүс .....	5
Үр Нөлөө.....	7
Зорилго.....	7
Итгэгчид ба үл итгэгчид.....	8
Үүрэг .....	9
<b>АРИУН</b> .....	<b>11</b>
Тодорхойлолт .....	11
Хүмүүс .....	13
Үзэгдэх Чуулган.....	14
Гүл Үзэгдэх Чуулган.....	16
<b>ДАЯАР ЧУУЛГАН</b> .....	<b>17</b>
Тодорхойлолт .....	17
Үзэгдэх Даяар Чуулган.....	19
Үл Үзэгдэх Даяар Чуулган.....	21
Нэг Аврагч .....	21
Нэг Итгэл Бишрэл .....	22
<b>НЭГДЭЛ</b> .....	<b>24</b>
Үзэгдэх чуулган .....	25
Нигүүлслийн Арга Замууд.....	25
Сүнслэг Бэлгүүд.....	27
Материаллаг зүйлс .....	27
Үл Үзэгдэх чуулган .....	28
Христтэй Нэгдсэн Нэгдэл .....	29
Итгэгчдийн Нэгдэл .....	30
<b>ДҮГНЭЛТ</b> .....	<b>31</b>
<b>ХАМТРАГЧИД</b> .....	<b>33</b>
<b>ҮГСИЙН ТАЙЛБАР</b> .....	<b>35</b>

# Элч нарын тунхаг

## 5-р хичээл

### ЧУУЛГАН

#### УДИРТГАЛ

---

Өнөө цагт ихэнх хүмүүс "чуулган" гэдэг үгийг сонсоод Бурханыг магтан хүндлэхээр Христитгэгчдийн цуглардаг барилга байшин гэж боддог болжээ. Зарим чуулганы барилгууд нь уран тансаг зураг чимэглэлтэй, хээнцэр гоёмсог, сүрлэг том сүм дуган байдаг. Харин зарим нь эгэл жирийн эд хогшилтой, энгийн даруу мөргөлийн байрууд байдаг. Мөн зарим чуулган нь аюулаас нуугдах орон гэр, оромж овоохой, шавар урц, нүх агуй ч байж болдог. Гэхдээ Элч нарын тунхагт, Библид бичсэнтэй л адилхан "чуулган" гэдэг үг нь анхнаасаа юун түүрүүнд Эцэг, Хүү, Ариун Сүнсэнд итгэх итгэлээрээ нэгдсэн Бурханы хүмүүс буюу ариун хүмүүсийн нэгдлийг хэлсэн байдаг юм.

Элч нарын тунхаг цуврал хичээлийн маань 5-р хичээл эхэлж байна. Энэ хичээлийн нэр бол "Чуулган". Энэ хичээлээрээ бид энэхүү ариун нэгдэлд итгэх итгэлийг хүлээн зөвшөөрдөг Элч нарын нарын тунхаг дахь нэгэн тунхаглалыг үзэх болно.

Элч нарын тунхаг нь чуулганы тухай тодорхой өгүүлсэн байдаг. Энд:

**"Би...**

**Ариун нэгдмэл чуулган,**

**Ариун хүмүүсийн нөхөрлөлд... итгэдэг" гэжээ.**

Тунхаг дахь эдгээр мөрүүд нь Ариун Сүнс болон Түүний үйлчлэлийн талаарх хэсэгт багтсан байдаг. Ариун Сүнс бол өдөр бүр чуулганы бүхий л зүйлд хамгийн их оролцдог Гурвалын нэг бодгаль учраас тэр биз ээ. Тиймээс бид Ариун Сүнсний тухай хичээлээрээ чуулганы талаар ярьж болох байсан. Гэвч бид чуулганы талаар тусад нь нэг бүтэн хичээл болгон оруулахаар шийдсэн юм. Учир нь энэ нь Христитгэл болон Христийн дагалдагчдын амьдралын чухал үндэс суурь болдог билээ.

Өмнөх хичээлээрээ дурдсанчлан чуулганд итгэх итгэлээ тунхаглах нь хачирхалтай хэрэг хэмээн олон протестант итгэгчид үздэг. Учир нь чуулганд итгэх нь Бурханд итгэх итгэлтэй эн зэрэгцэж байгаа мэт харагддаг гэдэг. Гэтэл тунхагт "би чуулганд... итгэдэг" гэж хэлэхдээ аврагдахын төлөө чуулганд итгэдэг гэсэн утгаар хэлээгүй юм. Зөвхөн Христэд итгэснээр л авралд хүрнэ шүү дээ. Харин бид Библи өөрөө чуулган бол Христитгэгчдэд чухал хэмээн заасан байдаг учраас л чуулганд итгэдэг билээ. Ариун хүмүүсийн нэгдэлд итгэх итгэл ч мөн адил юм. Бид аврагдахын төлөө бусад итгэгчдэд итгэдэггүй. Харин Бурхан бусад итгэгчдээр дамжуулан бидэнд сайнмэдээ хүргэж, үйлчилж, итгэлийг маань батжуулдаг юм хэмээн заасан Библийн сургаалд л итгэж буй нь энэ билээ.

Чуулганы талаарх энэ хичээлээ бид тунхагт тусгагдсан дөрвөн гол сургаалын дагуу хуваан авч үзнэ. Нэгдүгээрт, бид чуулганы тэнгэрлэг хүлээн зөвшөөрлийн тухай үзнэ. Хоёрдугаарт, чуулган бол ариун гэдэг үнэний тухай ярилцана. Гуравдугаарт, бид чуулган бол бүх нийтийн буюу даяар гэдэг талаас нь авч үзнэ.

Харин дөрөвдүгээрт, чуулган бол нэгдэл гэдэг санааг судлах юм. Эдгээр хэсгүүдийг үзэх нь тунхаг дахь чуулганы талаар өгүүлж буй түүний мөн чанар, онцлогийг ойлгож авахад бидэнд тусална. Ингээд чуулганы тэнгэрлэг хүлээн зөвшөөрлийн тухай эхлээд үзэцгээе.

## ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛ

---

Орчин цагт чуулганыг онцын шаардлагагүй гэж итгэдэг эсвэл яг тийм юм шиг ханддаг Христитгэгчид олон болжээ. Үнэнч итгэгчид хүртэл сүм чуулганыг Бурхантай харилцах харилцаанд нь хүчээр оруулж ирсэн, хүмүүний бий болгосон байгууллага мэтээр үзэх тохиолдлууд ч бий. Гэвч Библид тун өөрөөр заасан байдаг. Өргөн утгаар нь авч үзвэл чуулган бол газар дэлхий дээрх Бурханы хаанчлал, онцгой ард түмнийх нь нэгдэл, Өөрт нь итгэмжит хүмүүст энэрэл нигүүлслээ түгээх гол арга зам нь юм. Бичвэрийн дагуу чуулган бол бидний Бурхантай харилцах харилцааг барьж байгуулж, дэмжин тэтгэдэг нэн чухал газар билээ.

Бурхан чуулганыг хүлээн зөвшөөрсөн гэдэг нь Тэрээр чуулганыг зорилготойгоор бүтээж, эрх мэдлийг өгсөн гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл Бурхан чуулганыг батламжилдаг хэмээн Библид заадаг. Энэ бол Бурханы энэ дэлхий дээрх Өөрийн зорилгыг хэрэгжүүлэхээр байгуулсан нэгдэл тогтолцоо юм. Матай 16:18-р эшлэлд Есүс энэ тухай өгүүлсэн байдаг. Энд:

"Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй" гэжээ (Матай 16:18).

Чуулган бол гэм нүгэлд унасан хүн төрөлхтний байгуулсан зүйл биш ээ. Харин Есүс Өөрөө чуулганыг барьж байгуулагч нь юм.

Чуулганы түүхэнд олон алдаа оноо байсан. Заримдаа чуулган Сайнмэдээнээс гажиж,

Бурханы чуулган байхаа больсон тохиолдлууд ч бий. Хэдий тийм ч бид чуулганыг ямар ч хэрэггүй бас чухал биш гэж дүгнэж болохгүй ээ. Элч нарын тунхагт чуулганы тэнгэрлэг хүлээн зөвшөөрлийг энгийн үгээр батлан хэлсэн байдаг. Энд:

**"Би чуулганд...итгэдэг" гэжээ.**

Бид өмнөх хичээлүүдээрээ Элч нарын тунхаг бол анхны сүм чуулгануудын итгэлийн удирдамж зааврын хураангуй гэдгийг үзсэн. Харин тэдгээр итгэлийн удирдамж заавар нь Бичвэрийн хураангуй байдаг. Тиймээс чуулганд итгэх итгэлийг тунхагт тунхаглана гэдэг нь Библид чуулганы тухай юу гэж заасныг тунхаглаж байна гэсэн үг. Бурхан энэ дэлхий дээрх зорилгоо гүйцэлдүүлэхээр чуулганыг томилсон гэдэг нь чуулганы талаарх Библийн үндсэн сургаал мөн.

Чуулганы тэнгэрлэг хүлээн зөвшөөрлийн тухай бид гурван хэсэгт хуваан үзэх болно. Нэгдүгээрт, бид чуулганы талаар Хуучин Гэрээнд юу гэж бичсэнийг үзнэ. Хоёрдугаарт, Есүс газар дэлхий дээрх үйлчлэлийнхээ үеэр чуулганы үндэс суурийг тавихын төлөө юу хийснийг олж харна. Харин гуравдугаарт, библийн эдгээр үзэл

баримтлалын утга учир, үр нөлөөг судлах юм. Ингээд эхлээд Хуучин Гэрээн дэх чуулганы талаар авч үзэцгээе.

## Хуучин гэрээ

Шинэ Гэрээн дэх чуулганы талаарх ойлголт нь Хуучин Гэрээнд үндэслэсэн байдаг.

**Есүс тэнгэр өөд одож, дагалдагч нартаа Өөрийн Сүнснийг илгээсэн Пентекостын өдрөөс л чуулган эхэлсэн гэж олон хүн боддог. Гэвч энэ бол чуулганы мөн чанарын талаарх буруу ойлголт гэж би боддог. Чуулган бол Хуучин Гэрээн дэх Бурханы ард түмний үргэлжлэл юм л даа. Бурхан Абрахам болон Хуучин Гэрээний хүмүүсийг дуудсан. Тэгээд бид энэ бол чуулган байна, чуулганы эхлэл байна хэмээн хялбархан хэлж чадна. Тэгэхээр чуулган чухам тэр үеэс эхэлсэн бөгөөд бидний үед ч үргэлжилсээр байна. Тэгээд Есүс эргэн ирэх тэр өдрийг хүртэл буюу бүрэн төгс биелэх хүртэл үргэлжилсээр байх болно.**

-Др.Риад Кассис

Шинэ Гэрээнд чуулганы тухай ярихдаа *экклесиа* гэдэг Грек үгийг олонтоо ашигласан байдаг. Харин энэ үг нь Хуучин Гэрээний Грек орчуулга буюу Септуагиантаас гаралтай. Хуучин Гэрээнд *экклесиа* болон энэ үгийн Еврей хувилбарыг Израиль үндэстний цугласан түмний нэгдлийг илэрхийлэхдээ ашигласан байдаг. Дэд Хууль 9:10, 31:30, Шүүгчид 20:2, 1 Хаад 8:14, Дуулал 22:22, 25 болон өөр олон хэсгээс бид энэ тухай харж болно.

Шинэ Гэрээнд хэдийгээр *экклесиа* нь чуулганыг илэрхийлдэг үг хэллэг болсон ч үүнийг Хуучин Гэрээний Израилийг тодорхойлохдоо ашигласаар байгаа билээ. Тухайлбал, Үйлс 7:38-р эшлэлд Стефан өөрийг нь алсан хүмүүст ийнхүү хэлсэн байдаг. Тэрээр энд:

"[Моcе] Синаи уулан дээр өөртэй нь ярилцаж байсан тэнгэрэлчийн хамт бидний өвөг дээдэстэй цуг цөл дэх цуглаанд байсан хүн бол тэр юм. Та нарт өгөх гэж амьд илэрхийллийг тэрээр хүлээн авсан" гэжээ (Үйлс 7:38).

Энд цуглаан гэж орчуулагдсан Грек үг нь *экклесиа* гэдэг үг байдаг. Энэ нь ихэнхдээ "чуулган" гэж орчуулагддаг. Тэгэхээр Израилийн цуглаан нь Шинэ Гэрээний чуулгантай эн тэнцүү бөгөөд урьд үеийнх нь хувилбар байсан гэж хэлж болно.

Петр 2:9-р эшлэлд Петр чуулганыг Хуучин Гэрээнд Израилийг илэрхийлдэг байсан нэрээр дуудсан байдаг. Түүнийг юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

"Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм" гэжээ (1 Петр 2:9).

Энэ эшлэлд Петр Хуучин Гэрээнд Израиль үндэстний тухай өгүүлсэн хэд хэдэн хэсгээс эш татсан байна. Тэр Израилийн онцгой нэрсээр Шинэ Гэрээний чуулганыг нэрлэжээ. Ингэснээр тэрээр энэ хоёр чуулганы хооронд чухал үргэлжлэл байгааг тодорхой харуулж чадсан.

**Хэрэв бид 1Петр 2-р бүлгээс харвал Петр Хуучин Гэрээнд Израилийг нэрлэж байсан бүхий л нэрсийг одоогийн сүм чуулганд хамааруулсан. Тэрээр "Та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн" гэсэн. Тэрээр энд ихэвчлэн газар газрын харь үндэстэн чуулгануудад хандан бичсэн байдаг. Ингэхдээ тэднийг өөрсдийгөө Бурханы Израильд өгсөн амлалтын биелэл гэдгийг олж харж, хэн болохоо үнэхээр ойлгож мэдээсэй хэмээн хүссэн юм аа.**

**-Др. Деннис И. Жонсон.**

Мэдээж Шинэ Гэрээний чуулган Хуучин Гэрээн дэх Израилийн цуглаантай яг таг бүх талаараа адил гэсэн үг биш юм. Энэ хоёр холбоотой төдийгүй ялгаатай байдаг. Ром 11-р бүлэгт Паул Хуучин Гэрээн дэх Израилийн цуглаан болон Христийн чуулганы хоорондын холбоог тайлбарлахын тулд хоёр зүйрлэл ашигласан. Тэрээр тэдгээрийг өргөл дээж буюу гурилын зуурмаг ба чидуны мөчиртэй зүйрлэжээ.

Ром 11:16-р эшлэлд түүнийг юу гэж хэлснийг харцгаая. Энд тэрээр:

"Өргөл дээж ариун бол үлдсэн нь бүхэлдээ мөн тийм, үндэс хэрэв ариун бол мөчрүүд нь ч бас тийм байна (Ром11:16).

Нэгдүгээрт, Паул Хуучин Гэрээний цуглаан нь Шинэ Гэрээний чуулган бий болсон нэг л гурилын зуурмагийн өргөл дээж нь байсан юм гэж хэлсэн байна.

Левит 23:17-д Израилийг талх тарианыхаа анхны өргөл дээжийг Эзэнд өргөхийг шаардсан байдаг. Өргөл дээж гэдэг нь ямар нэг тусдаа ургац байгаагүй юм. Харин бүх ургацын нэг хэсэг нь байсан бөгөөд ургацыг бүхэлд нь төлөөлдөг байв. Тиймээс Израиль болон Шинэ Гэрээний чуулган нэг л ижил гурилын зуурмагаас гаралтай гэж хэлсэнээрээ Паул Израиль ба Шинэ Гэрээний Христитгэгчид бүгдээрээ нэг бүхэл нэгдэл, нэг адил Бурхан, нэг ижил чуулганы хэсэг гэсэн санаа юм.

Хоёрдугаарт, Хуучин Гэрээний цуглаан бол модны үндэс, харин Шинэ Гэрээний чуулган бол тэр модны мөчрүүд хэмээн Паул хэлжээ. Паул энэ зүйрлэлээ хэд хэдэн олон хэсэгт дэлгэрүүлэн тайлбарласан байдаг. Тэрээр бүх цаг үеийн чуулганыг боловсорч гүйцсэн модтой адилтгажээ. Иудейчүүдээс голчлон бүрдсэн Хуучин Гэрээний чуулганыг модны гол хэсэг буюу үндэс, их бие, мөчир гэжээ. Харин харь үндэстэн Христитгэгчид бол тэрхүү модонд залгагдсан зэрлэг чидуны мөчрүүд гэсэн байна. Өөрөөр хэлбэл харь үндэстэн итгэгчид нь Израилийн чуулганд залгагдсан гэсэн үг юм. Хэдийгээр Паулын цаг үед чуулганд Иудей болон харь үндэстэн итгэгчид багтаж байсан ч үүний их бие ба үндэс нь Хуучин Гэрээний цаг үеийн туршид ургасаар байсан нэг л ижил мод байв. Тийм ээ, мэдээж энэ шинэ мод олон талаараа өөр. Энэ мод илүү өсөж урган, боловсорсон. Гэсэн ч энэ нь өнөөх мод

хэвээр л байна. Яг үүнчлэн Хуучин Гэрээний чуулган өсөж хөгжөөд, Шинэ Гэрээний чуулган болж боловсорсон юм. Тэдний хооронд чухал ялгаанууд байгаа ба эдгээр ялгаанууд нь өсөлт хөгжлийнх нь үе шатуудыг төлөөлдөг. Гэвч тэд нэг л ижил чуулган мөн билээ.

Ингээд бүгдээрээ чуулганы хүлээн зөвшөөрлийн тухай Хуучин Гэрээний өнцгөөс авч үзлээ. Харин одоо Есүс Хуучин Гэрээний чуулганыг итгэмжлэн, ахиц дэвшлийг авчрах замаар Өөрийн чуулганыг хэрхэн байгуулсан тухай харцгаая.

## Есүс

Есүс ирснээр Түүний газар дэлхий дээрх үйлчлэл нь энэ дэлхийд болоод Бурханы ард түмэнд гайхамшигтай нөлөө үзүүлсэн гэдэгтэй маргах хүн үгүй биз ээ. Есүс зүгээр л Хуучин Гэрээний чуулганыг оролцуулаад түүний дүрэм зааврыг тэр чигт нь хадгалан авч үлдээгүй гэдгийг олон теологичид онцолдог нь учиртай. Яг үүнтэй зэрэгцэн Есүс мөн цоо шинэ чуулганыг ч бий болгоогүй гэдгийг ойлгох нь чухал. Түүний байгуулсан чуулган бол Хуучин Гэрээний чуулганы гайхалтай үргэлжлэл байсан юм.

Есүс чуулганыг эклессиа гэдэг нэрээр гурван удаа дуудсан нь Сайнмэдээний номуудад бичигдэн үлдсэн. Үнэндээ Матай, Марк, Лук, Иохан номд эклессиа гэдэг үгийг дурдсан өөр тохиолдол байхгүй. Энэ гурван тохиолдлын нэг нь Матай 16:18, нөгөө хоёр нь 18:17-р эшлэлд тус бүр байдаг. Одоо эдгээр багц эшлэлд анхаарлаа хандуулъя.

Матай 16:18-р эшлэлд Есүс ингэж хэлсэн байна:

"Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй" гэжээ (Матай 16:18).

Энд "босгох" гэж орчуулагдсан ойкодомео гэдэг үгийг цоо шинэ зүйл босгон байгуулах эсвэл хэдийнээ байсан зүйлийг дахин сэргээн босгох гэсэн аль аль утгаар нь ашигладаг. Хэдийгээр Есүс яг аль утгаар нь ашиглаж байгаагаа тодорхой хэлээгүй ч Ром 11-р бүлэгт Паулын заасан зүйлээс бид Есүс Хуучин Гэрээний чуулганыг дахин сэргээж, барьж байгуулсан гэж ойлгож болохоор байдаг.

Матай 18:17-р эшлэл дэх Есүсийн үгс илүү тодорхой байна. Түүний хэлсэн үгийг сонсоцгооё. Энд:

"Тэр тэднийг сонсохоос татгалзвал чуулганд хэл. Хэрэв чуулганыг ч хүртэл эс сонсвоос тэр чиний хувьд харь хүн ба татвар хураагч мэт байг" гэжээ (Матай 18:17).

Энэ эшлэлд Есүс чуулганы сахилгажуулалтын тухай ярьж байна. Түүний сургаалын гол утга нь гэмээ орхиогүй хүнийг чуулганы өмнө авчрах тухай юм. Есүсийн үйлчлэлийн үед чуулган нь чухамдаа газар сайгүй тархсан Иудейн синагогууд хийгээд Иерусалим дахь сүм л байсан шүү дээ. Эдгээр нь мэдээж Израилын чуулганы Хуучин Гэрээний өөр өөр хэлбэрүүд байсан хэдий ч Есүс тэдгээрийг "чуулган" гэж дуудсан юм.



Хуучин Гэрээнд шүүхээр томилогдсон чуулганы эрх бүхий төлөөлөгчид болох - ахлагчид, тахилчид, шүүгчид л аливаа маргаан, зөрчлийг шийдвэрлэх ёстой гэсэн байдаг. Бид энэ талаар Гэтлэл 18, Дэд Хууль 1 ба 9 зэрэг эшлэлээс харж болно. Есүс сонсогчдодоо хандан маргаанаа Израилын чуулганы дотор шийдвэрлэх үүрэгтэй хэвээр байгаа гэж сануулснаараа энэ зарчмыг өөрийн цаг үедээ баталгаажуулсан. Мөн Есүс энэ үгээ үүний өмнө Матай 16-р бүлэгт дурдсан Өөрийн чуулгандаа ч мөн хэрэгжүүлэх зорилгоор хэлсэн юм. Матай ч бас Есүсийн энэ үгсийг бичсэн байдаг нь учиртай. Есүс болон Матай хоёрын санаа Паулын Шинэ Гэрээний сүм чуулган бол Израилын Хуучин Гэрээний чуулгануудын үргэлжлэл гэдэг санаатай яв цав нийцэж байгааг анзаарав уу. Есүс Израилыг чуулган болгон солих гэж биш, харин Израилыг Шинэ Гэрээний чуулган болгон сэргээн босгохоор ирсэн билээ.

Хуучин болон Шинэ Гэрээний чуулганы залгамж холбооны тухай үзэхдээ бид энэ хоёр чуулганыг холбох гол үүргийг Есүс гүйцэтгэж байгааг ойлгох нь чухал.

Юуны өмнө, ерөнхийдөө, Есүсийг Бурханы Израилд өгсөн амлалтын биелэл гэж Шинэ Гэрээнд танилцуулсан байдаг. Ром 8:1-4, мөн Галат 3:16-29-р эшлэлүүдээс бид Есүс бол Бурханы гэрээг сахидаг, Бурханы Абрахам, Мосед амласан бүхий л ерөөлийг өвлөн авсан итгэмжит Израил хүн байсныг харж болно. Харин Лук 1:32 болон Үйлс 2:31-33-р эшлэлд Есүс бол Давидын хаан ширээг сэргээж, Израил, Иудейг захирах Давидын удам гэсэн байдаг. Есүс Хуучин ба Шинэ Гэрээний харилцаа холбоог таслан зогсоохоор ирээгүй. Тэр бол Өөрөө Хуучин Гэрээний чуулганы туйлын дээд оргил буюу чуулганы хамгийн төгс гишүүн бас үйлчлэгч нь байсан юм.

Хоёрдугаарт, Есүс бол Шинэ Гэрээний чуулганы үндэслэгч буюу уналтад орсон байсан Хуучин Гэрээний чуулганыг Шинэ Гэрээний чуулган болгон өөрчилж, сэргэлт ба шинэчлэлтийг авчирсан Нэгэн билээ. Ефес 5:23, Колоссай 1:18-р эшлэлүүдэд Түүнийг чуулганы тэргүүн гэсэн байдаг. Харин Ефес 5:22-23 болон Илчлэл 19:1-10-р эшлэлүүдэд Түүнийг чуулганы эр нөхөр гэжээ. Матай 28:18-20-р эшлэлд буй Агуу Тушаал дахь эрх мэдлийг хүлээн авхуулахаар Есүс Өөрөө чуулганыг томилдог. Есүс чуулганы хайрлаж, бататгаж, мөн эрх мэдлийг өгдөг.

**Хуучин Гэрээний чуулганы Есүс Христтэй харилцах харилцаа нь мөн чанартаа Шинэ Гэрээний чуулганы Есүс Христтэй харилцах харилцаатай яг ижилхэн байдаг. Зарим итгэгчдийн хувьд Хуучин Гэрээний чуулган гэдэг нэр жаахан хачин санагдаж байгаа байх. Бидний зарим нь Үйлс 2-р бүлэг дэх Пентекостын өдөр л чуулган анх бий болсон гэж боддог байж болох юм. Гэвч хэрэв бид чуулган гэдгийг Бурхантай гэрээ байгуулсан, Эзэн Есүс Христээр дамжуулан аврагдсан Бурханы хүмүүсийг хэлнэ гэж үздэг юм бол Хуучин Гэрээний чуулган ч мөн Мессиагийн ирэлтээр гүйцэлдэх Бурханы авралыг хүсэн хүлээж буй итгэгчдийн бие байсан юм шүү дээ. Тиймээс Хуучин Гэрээний чуулган Бурханы нигүүлсэл, Бурханы урсгасан цус буюу загалмай дээрх Есүс Христийн цусанд итгэдэг байсан. Хуучин Гэрээний Христитгэгчид буюу Хуучин Гэрээний итгэгчид болох Хуучин Гэрээний чуулганы гишүүд бүгд Их Эзэн Есүс Христийн гүйцэлдүүлсэн үйл хэргийг хүсэн хүлээдэг**

**байсан юм. Тэд гэм нүглийг нь уучилж, Бурханд зөвд тооцуулах Түүний бүхнээс хүчит, болзолгүй нигүүлсэл, өршөөлд итгэж найддаг байлаа. Тиймээс хамгийн гол нь Хуучин Гэрээний итгэгчид ба чуулган, тэдний Бурхантай харилцах харилцаа нь Шинэ Гэрээний итгэгчид ба чуулган болох бидний Бурхантай харилцах харилцаатай яг адил байгааг ойлгох хэрэгтэй юм.**

**-Др. Самуел Лин**

Ингээд бүгдээрээ энэ хүртэл чуулганы хүлээн зөвшөөрлийг Хуучин Гэрээний нөхцөл байдал, Есүсийн газар дэлхий дээрх үйлчлэлтэй холбон авч үзлээ. Тэгэхээр одоо бид эдгээр нь чухам ямар үр нөлөөтэй байсан тухай үзэхэд бэлэн боллоо.

## Үр нөлөө

Шинэ Гэрээний чуулган бол Хуучин Гэрээний Израилын сэргээн шинэчлэгдэн хөгжсөн хувилбар гэсэн Есүсийн сургаалаас бидний олж хардаг нэгэн чухал утга учир бол Хуучин Гэрээний Израил болон Шинэ Гэрээний Христитгэгчдийн хоорондох үндсэн суурь залгамж холбоо яахын аргагүй мөн. Бодит амьдрал дээр Шинэ Гэрээн дэх Бурханы хүмүүсийн нэгдэл нь Хуучин Гэрээний үндсийг тусган харуулах ёстой юм. Мэдээж ялгаатай зүйлс бий. Шинэ Гэрээ нь тэдгээр ялгаатай зүйлст анхаарсан байдаг. Гэхдээ Шинэ Гэрээнд ч гэсэн чуулган нь Израилтай тун адилхан тухай заадаг шүү дээ.

Тэдгээр залгамж чанаруудыг дурдвал тоймгүй олон бий. Гэхдээ тэдгээрийн тодорхой гурвыг нь дурдах нь зүйтэй. Нэгдүгээрт, Хуучин Гэрээний чуулган ба Шинэ Гэрээний чуулганы хооронд залгамжлан ирсэн агуу зорилго гэж бий.

## Зорилго

Теологичид дэлхийн түүхийг ерөнхийд нь гурван үе шатад хураангуйлан хуваадаг: Эдгээр нь бүтээлийн, уналтын болон авралын үе юм. Бүтээлийн үе шатыг Эхлэл номын 1-2-р бүлэгт дүрсэлсэн байдаг ба Бурхан энэ дэлхийг, ургамал, амьтад бас хүн төрөлхтнийг бүтээсэн. Тэр үед Бурхан мөн дэлхийн нэгэн онцгой газарт Еден цэцэрлэгийг бүтээсэн байдаг. Бурханы төлөвлөгөөний дагуу хүн төрөлхтөн өсөж үржин, газар дэлхийг захирч, Еден цэцэрлэгийн нэгэн адил Бурханы ариун оршихуйд зориулсан газар болгон өргөжүүлэн тэлэх явдал байсан юм.

Уналтын үе шатыг Эхлэл 3-р бүлэгт бичсэн байдаг. Хүн төрөлхтөн Бурханы эсрэг тэрсэлж, Еден цэцэрлэгээс хөөгдсөн. Мөн хүн төрөлхтөн гэм нүгэлд унаж, бүх бүтээлийг завхруулсан. Ром 8:20-22-р эшлэлд Паул энэ тухай тайлбарласан байдаг.

Харин түүхийн үлдсэн хэсэгт авралын үе шатын тухай өгүүлдэг. Бурхан хүн төрөлхтний төгс төгөлдөр байдлыг сэргээн, тэгээд хүн төрөлхтнөөр дамжуулан бүх бүтээлийг анх байсан шиг нь болгохоор ажиллаж байна. Авралын үе шатын сүүлчийн хэсэгт шинэ тэнгэр газар бий болно гэж Исаиа 65:17, 66:22, 2 Петр 3:13 болон Илчлэл 21:1 зэрэг эшлэлүүдэд өгүүлдэг. Хүн төрөлхтөн болон бүтээлийг аврах нь хоёр Гэрээн дэх Бурханы чуулганы зорилго байсаар ирсэн.

Орчин үеийн дэлхийд ч чуулган бүтээлийг сэргээх энэ л зорилгын төлөө тэмцсээр байна. Шинэ Гэрээний сургаал номлолд чухалчлан заасны дагуу бид энэ авралын эцсийн үе шатанд хүрэх алхмууд болох Сайнмэдээг номлож, хүн бүрийг Христ дээр авчрах ажлыг голчлон хийж байна. Мөн энэ дэлхийд Христитгэгчийн амьдралаар амьдарч, хөршүүддээ Христийн хайрыг харуулж, Бурханы зан чанар, алдар хүнд, сүр жавхлангийн толь болж, эргэн тойрондоо өөрчлөлтийг түгээснээрээ бид мөн уг зорилгыг хэрэгжүүлдэг. Түүнчлэн бид Есүс эргэн ирж, золилтын үйлсээ гүйцээх тэр өдөрт найдан, залбирснаараа энэхүү зорилгоо гүйцэлдүүлж байна.

Хуучин Гэрээний чуулганаас одоогийн Шинэ Гэрээний чуулганд залгамжлан ирсэн хоёр дахь гол залгамж чанар бол Бурханы хүмүүсийн чуулгануудад итгэгчид ба үл итгэгчид багтдаг явдал юм.

## Итгэгчид ба үл итгэгчид

Хуучин болон Шинэ Гэрээний алинд ч чуулган төгс байгаагүй гэдгийг санаарай. Хуучин Гэрээнд эртний зарим Израилчууд Бурханд итгэмжит байж, ерөөл ивээлийг нь хүртэж байсан. Гэвч итгэлгүйгээсээ болж Бурханд тэрсэлж, тэнгэрлэг хараалд унаж байсан нь олон шүү дээ. Хуучин Гэрээнээс бид ийм жишээ олныг харж болно. Гэхдээ Бурханы гэрээний ерөөл ба хараалын тухай хамгийн ойлгомжтой хураангуйг бид Левит 26 болон Дэд Хууль 27-30-р бүлгүүдээс харж болдог.

Есүсийн дагалдагч нарын чуулган буюу Шинэ Гэрээний чуулганд ч бас яг ийм зүйл болдог. Чуулганд итгэгчдийн дунд үргэлж итгэгч биш хүмүүс холилдон байдаг. Жишээ нь, Иудас элч нарын дотроос итгэлгүй нэгэн нь байсан. Ялангуяа энэ тухай Иохан 6:70-71-р эшлэлд тодорхой дурдсан байдаг. Мөн түүний Христээс урвасан тухай ч бий. Чуулганы янз бүрийн шинж чанарууд нь Илчлэл номын 2-3-р бүлэг дэх чуулгануудад хандсан захидлаас ч тодорхой харагддаг. Илчлэл номын эдгээр бүлгүүдийн гол санаа нь чуулган дахь жинхэнэ итгэгчид тэсвэрлэн гарах тухай байдаг. Мөн тэсвэрлэж чадаагүй нь итгэлгүй гэдгээ харуулж буй хэрэг гэсэн байдаг. Түүнчлэн 1 Иохан захидлын ихэнх хэсэг нь чуулганы жинхэнэ ба хуурамч итгэгчдийг ялган таних тухай байдаг. Үүнээс гадна чуулганы хуурамч багш нарын тухай, эсвэл итгэлээ сахихын тулд эцсээ хүртэл тэссэн итгэгчийг урамшуулах тухай өөр олон багц эшлэлүүд бий.

2bКоринт 13:5-р эшлэлд Паул энэ үнэнийг олж харан, энэ талаар эргэцүүлэн бодохыг уриалсан байна. Тэрээр энд:

"Та нар итгэлд байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө судал. Эсвэл Есүс Христ та нарын дотор байгааг та нар өөрсдөө мэддэггүй юм уу? Та нар үнэхээр шалгалтдаа унадаггүй л юм бол!" гэжээ (2 Коринт 13:5)

Чуулганы гишүүн байх, баптисм хүртэх, үнэнч дэг журамтай итгэгч байх зэрэг нь Есүс Христ доторх авралд хүргэх итгэлийн бүрэн баталгаа болохгүй гэдгийг хүн бүр ойлгоосой гэж Паул хүссэн. Христэд үнэнээсээ итгэдэггүй хүмүүс ч эдгээрийг хийж чадна. Тиймээс Паул чуулганы хүмүүсийг өөрсдийгөө шалгаж, үнэхээр Христэд итгэж авралд хүрсэн эсэхээ баталгаажуулахыг хүссэн.

Мэдээж, бид хүн болсон хойно өөр хүний зүрх сэтгэлийг нэвт харж чадахгүй. Бид зөвхөн нэг нэгнийхээ үгийг сонсож, үйлдлийг л харж чадна. Тиймээс бид

хүмүүсийг жинхэнэ итгэгч мөн эсэхийг хэлэх бараг боломжгүй. Гэхдээ чуулганд маань үл итгэгчид ч байж магадгүй гэсэн мэдлэг нь өөрсдийгөө төдийгүй бусдыг харах хараанд маань нөлөө үзүүлэх ёстой юм. Жинхэнэ итгэгч мөн эсэхийг нь бид мэдэхгүй байж болох ч хараахан итгэж амжаагүй байгаа тэдгээр хүмүүст зориулан Сайнмэдээг номлож, сургасаар л байх хэрэгтэй. Мөн бид Христэд хараахан итгэж амжаагүй хүмүүсийг чуулганд ирэх урам зоригийг нь мохоож болохгүй. Бид Бурханыг эрэн хайж байгаа нэгнээ хүлээн авдаг байх хэрэгтэй. Бид бие биедээ тэсвэртэй хандаж, чуулганд ирээд удсан хэдий ч итгэл болон төлөвшил харилцан адилгүй байж болно гэдгийг ойлгох нь зүйтэй.

Хуучин Гэрээний чуулганаас Шинэ Гэрээний чуулганд залгамжлан ирсэн гурав дахь залгамж холбоо бол Бурханы өмнө хүлээсэн нэг ижил үүрэг юм.

## Үүрэг

Хуучин ба Шинэ Гэрээн дэх Бурханы хүмүүсийн аль аль нь Бурханыг хайрлаж, хаанчлалыг нь дэлхий дахинаа түгээж, Бурхандаа алдар хүндлэлийг өргөх үүрэг хариуцлагатай. Бурханыг хайрлах тухайд Дэд хууль 6:5-6-р эшлэлд Хуучин Гэрээний чуулганыг Бурханаа чин сэтгэлээсээ хайрлаж, хуулийг нь чин сэтгэлээсээ дагахыг сургасан байдаг.

Үүнтэй яг адил Шинэ Гэрээний чуулган нь Бурханыг хайрлаж, хуулийг нь дагахаар дуудагдсан. Есүс Матай 22:37-р эшлэлд Бурханыг чин сэтгэлээсээ хайрлах нь хуулийн хамгийн агуу тушаал гэж заасан. 1 Иохан 5:3-р эшлэлд Иохан Бурханыг чин сэтгэлээсээ хайрлавал тушаалуудыг нь бас чин зүрхээрээ дагадаг гэсэн байдаг.

**Шинэ Гэрээний чуулган нь Хуучин Гэрээний чуулганы хуулийг дагах шаардлагатай юу гэж хүмүүс ихэвчлэн асуудаг. Үүний хариулт бол эргэлзэх юмгүйгээр тийм бас үгүй. Үгүй гэдэг нь Хуучин Гэрээний Торад байдаг тодорхой зааварчилгаанууд нь үнэндээ бидний хувьд хүчингүй болсон. Бид хөвгүүдээ хозлох шаардлагагүй. Бид жилд гурван удаа Сүмд очих хэрэггүй. Бид ингэх хэрэггүй, тэгэх хэрэггүй болсон.. гээд л олон зүйлсийг жагсааж болно. Яг үүний талаар л Иерусалимын зөвлөлд хэлэлцэснийг Үйлс 15-р бүлэгт бичсэн байдаг. Тэгвэл Хуучин Гэрээний Торагийн гол зорилго юу байсан юм бэ? Тора нь бидэнд Бурханы зан чанар, мөн чанарыг, мөн бидний хуваалцах ёстой зан чанар, мөн чанарыг илчилдэг гэдэг утгаараа, тийм ээ, Тора одоо ч хүчинтэй юм. Паулын захидлуудаас бид үүний тухай бас хардаг шүү дээ. Паул захидал бичиж байгаа хүмүүстээ хандан, "Үгүй ээ, та нар эрх чөлөөтэй. Та нар тэр бүхнийг хийх шаардлагагүй. Гэхдээ та нар чөлөөтэй учраас, хулгай хийхгүй, худал хэлэхгүй, тачаалд автахгүй, завхайрахгүй" гэсэн байдаг шүү дээ. Тиймээс Христитгэгчдийн хувьд авралд хүрэхийн тулд Тораг дагах шаардлагатай юу? Мэдээж үгүй. Гэхдээ аль хэдийн аврагдсан хүмүүсийн хувьд бид Бурханы амьдралыг хуваалцаж, харуулах ёстой болсон гэсэн үг үү? Тийм ээ.**

-Др. Жон Освалт

Хуучин ба Шинэ Гэрээн дэх Бурханы хүмүүсийн аль аль нь Бурханы хаанчлалыг дэлгэрүүлэх ёстой байдгийг харав уу. Эхлэл 17:4-5-р эшлэлд Бурхан Абрахамд олон үндэстний эцэг болно гэж амласан байдаг тул Хуучин Гэрээний чуулган үүнийг мэдэж байсан гэсэн үг. Паулын Ром 4:13-т заасны дагуу энэхүү амлалт нь Бурханы хаант хаанчлалыг итгэлээр бүх дэлхийд түгээх үүргийг тэдэнд өгсөн гэдгийг Хуучин Гэрээний чуулган мэдэж байсан. Үүний нэгэн адил Шинэ Гэрээний чуулган Сайнмэдээг бүх үндэстэнд түгээх замаар энэхүү зорилгыг үргэлжлүүлсээр байгаа. Матай 28:19-р эшлэлд Есүс чуулгандаа ингэж тушаасан байна. Энд:

"Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуул" гэжээ (Матай 28:19).

Хуучин Гэрээний Израил болон Шинэ Гэрээний чуулганы аль алинд нь байдаг гурав дахь үүрэг бол Бурханыг алдаршуулах явдал юм. Дуулал 86:12, Дуулал 115:18-р эшлэлүүдээс бид Хуучин Гэрээний чуулганы тухай харж болно. Бүр Хуучин Гэрээний үеийн тухай Шинэ Гэрээнд тайлбарласныг нь Үйлс 17:24-28 гэх мэт эшлэлүүдээс харж болдог. Эхлэл 1:27-р эшлэлд зааснаар бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн нь энэ үүрэгт бас их нөлөөлдөг. Хуучин Гэрээний цаг үед хаадын дүр төрхөөр урласан хөшөө баримал нь хүмүүст хаадыг хайрлаж, хүндэлж, дагахыг сануулах зорилготой байсан. Тэгвэл Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс Бурханаа алдаршуулахаар бүтээгдсэн юм шүү дээ.

Үүнтэй яг адилаар Шинэ Гэрээний чуулган ч бас Бурханыг алдаршуулан хүндлэхийн тулд байдаг юм. 1 Коринт 10:31, 1 Петр 4:11, Илчлэл 4:11 зэрэг өөр олон олон эшлэлд энэ тухай заасан нь бий.

Христ дотор байсан цагт Бурханаас чуулганд оноосон эдгээр үүргүүд үнэндээ дарамт биш. Гэхдээ бид Бурханы өмнө өөрсдийн хүчээр бүхнийг хийх гэвэл үүрэг хариуцлагаа дийлэхгүй дарагдах нь лавтай. Харин чуулганы итгэгчид Христийн дотор байвал буруутгалаас ангид байж, алдаа гаргахаас айхгүйгээр Эзэний хаанчлалыг тэлж, хуулийг нь сахиж, Түүнд алдар хүндлэлийг авчрах ажлаа ажрахгүй хийх болно. Үнэндээ бидний ялалт амжилт аль хэдийн баталгаажсан. Бид зуурдхан ухарсан ч Бурханы зогсошгүй ялалтын түүх урагш түрсээр л байдаг. Гол нь энэ ялалт чуулганаар дамжин ирэх учиртай. Тиймээс бид дуулгавартай байх тусам үүрэг хариуцлагаа биелүүлж чадна. Тэгснээр Бурхан хаанчлалаа бүрэн төгс сүр жавхланд нь удахгүй хүргэх болно.

Ингээд чуулган Хуучин Гэрээний анхны сууриасаа эхлэн Шинэ Гэрээн дэх Есүсийн батлан зөвшөөрсөн бие болох хүртэлх үйл явцыг харснаар Бурхан чуулганыг бүрэн дүүрнээр баталгаажуулсан гэдэг нь тун ойлгомжтой боллоо. Бурхан чуулганыг оршин байхыг хүссэн учраас л чуулган оршин байдаг. Энэ нь Бурханы зорилгыг гүйцэлдүүлдэг юм. Чуулган бол хүний санаачлан бий болгосон зүйл биш. Мөн библийн шашны нэг гажуудал төдий зүйл ч биш. Харин чуулган бол Бурханы хайрыг хүртсэн, Түүнийг алдаршуулан, Түүнд үйлчлэхийн төлөө байдаг Христийн сүйт бүсгүй болон бие билээ.

Тэгэхээр бид чуулганы хүлээн зөвшөөрлийн тухай ойлголттой болсон тул одоо хоёр дахь гол сэдэв болох чуулган бол ариун гэдэг үнэний тухай үзэхэд бэлэн боллоо.

## АРИУН

---

Ариун гэдэг санааг Библид тодорхойлохдоо олон өөр үг ашигласан байдаг. Шинэ Гэрээнд чуулганыг ариун эсвэл ариусгагдсан гэсэн үгээр дүрсэлдэг. Мөн чуулганы гишүүдийг ариун хүмүүс гэж нэрлэсэн байдаг. Ариун, ариусгагдсан, ариун хүмүүс гэсэн энэ гурван үг нь Грек хэлний нэг үгнээс гаралтай. "Ариун" гэдэг үгийг хагиос гэдэг тэмдэг нэрээр орчуулдаг. "Ариусгагдсан" гэдэг үг нь ариун гэсэн утгатай хагиозо гэдэг үйл үгнээс гаралтай. Харин "ариун хүмүүс" гэдэг үг бол ариун нэгэн гэсэн утгатай хагиос гэдэг нэр үг юм.

Хуучин Гэрээнд ариун гэдэг утга санааг Еврей хэлний кадош хэмээх тэмдэг үгээр, ариун болгох гэдгийг мөн кадаш гэдэг үйл үгээр, харин ариун нэгэн гэсэн санааг кодеш гэх нэр үгээр тус тус илэрхийлсэн байдаг.

Харин бид ариун байдлын тухай ярихаар ариун байдал нь Бурханыг бүтээлүүдээс нь ялгадаг гол шинж чанар гэж боддог Христэд итгэгчид олон. Өөрөөр хэлбэл Бурханы ариун байдал нь Түүний бүтээлүүдээсээ тэс өөр, бүхий л талаараа өөр байдаг чанар нь гэж ойлгодог гэсэн үг. Гэвч "ариун" гэдэг үгийг Библид зөвхөн энэ утгаар ашигладаггүй. Аливаа бүтээл ба юмс нь Бурханы ариун байдлыг тусган харуулах онцгой чанартай байх үед тэдгээрийг ч мөн ариун хэмээн Библи тодорхойлдог. Чухамхүү энэ л утгаараа Элч нарын тунхагт чуулганыг ариун гэж заасан байдаг юм.

Чуулган ариун гэдэг ойлголтыг бид хоёр хэсэгт хуваан үзэх болно. Нэгдүгээрт, бид "ариун" гэдэг үгийн тодорхойлолтыг судална. Хоёрдугаарт, тэр тодорхойлолтоо ариун хүмүүсийг танихдаа ашиглах болно. Ингээд эхлээд ариун байдлын талаарх библийн тодорхойлолтыг авч үзье.

### Тодорхойлолт

Библи дэх ариун байдлын талаарх ойлголт нь тун цогц ойлголт байдаг. Гэхдээ Библид хэн нэгнийг эсвэл ямар нэг юмыг ариун гэвэл үүний хамгийн гол санаа нь тэр бол ёс суртахууны хувьд цэвэр ариун гэсэн утгатай байдаг. Мөн үүнтэй холбоотойгоор "ариун" гэдэг үгээр Бурханы онцгой үйлчлэлд зориулагдан тусгаарлагдсан хүн эсвэл юмсыг бас тодорхойлдог.

Энэ тодорхойлолтын хоёр талыг хамтдаа харцгаая. Эхлээд ёс суртахууны хувьд цэвэр ариун байдлын тухай үзье. Хэн нэгэн эсвэл ямар нэгэн зүйл ёс суртахууны хувьд ариун байна гэдэг нь гэм нүглээс, завхралаас ангид гэсэн утгатай. Тэгэхээр ёс суртахууны утгаар нь авч үзвэл ариун байдал нь Бурханы зан чанарт суурилдаг. Библид Бурханыг Ариун Нэгэн хэмээн 2 Хаад 19:22, Сургаалт Үгс 9:10, Исаиа 30:11-15 болон 1 Иохан 2:20 гэх мэт олон эшлэлд тодорхойлсон байдаг.

**Энэ нь Бурхан зүгээр л биднээс хүчирхэг, хязгааргүй мөнх, харин бид хязгаарлагдмал байдаг тухай биш юм. Харин Тэрээр ёс суртахууны хувьд ч биднээс хавь илүү агуу гэсэн үг юм. Түүний дотор харанхуй эсвэл өөрчлөгдөх сүүдэр ч үгүй. Түүний дотор бурууг хийх хорон муу зорилго, төлөвлөгөө байхгүй. Түүний дотор ёрын мууг үйлдэх өчүүхэн төдий ч сэдэл эсвэл хүсэл байхгүй.**



**-Др. Ж. Лигон Дункан III**

Бурхан туйлын ариун учраас Түүний оршихуйд орох гэм нүгэлтэй ямар ч зүйл Түүний шүүлт ба уур хилэнгээс мултарч чадахгүй. Бид энэ тухай 1 Самуел 6:20, 2 Хаад 24:3, мөн Еврей 12:14 зэрэг эшлэлүүдээс харж болно. Хэдийгээр Бурхан одоохондоо шүүлтээ түр азнаж байж болох ч Түүний ариун оршихуй гэм нүгэл нь төлөгдөөгүй бүхнийг эцэст нь устгах болно. Тиймээс Түүний оршихуйд орох хэн ч, юу ч эхлээд ариун болсон байх ёстой. Жишээ нь, Исаиа 6:3-7-р эшлэлд юу гэж хэлснийг үзье:

" [Сераф] Нэг нь нөгөөгөө дуудаж, "Түг түмдийн ЭЗЭН, Ариун, ариун, ариун..."...Тэгээд би —Би сүйрсэн тул золгүй еэ! Би бузар уруултай хүмүүсийн дунд амьдардаг, бузар уруултай хүн. Гэвч нүд минь түг түмдийн ЭЗЭН болох Хааныг харлаа гэж хэлэв. Тэгэхэд серафуудын нэг нь тахилын ширээнээс хямсаагаар авсан, шатаж байгаа нүүрс гартаа барин над руу нисэж ирэв. Тэгээд тэр аманд минь хүргэж "...чиний хилэнц авч хаягдаж, чиний нүгэл уучлагдлаа" гэв (Исаиа 6:3-7).

Энэ эшлэлд Исаиа гэм нүгэл ба буруутгалаасаа болж Ариун Эзэний онцгой оршихуйд устгагдах вий гэж айсан байна. Тэгэхэд нь сераф буюу Бурханы тэнгэрэлчүүдийн нэг нь Бурханы тахилын ширээнээс шатаж буй нүүрсийг авч, Исаиагийн гэм нүглийг цэвэрлэн, түүнийг ариун болгожээ. Ийнхүү ариусгагдсанаараа тэрээр Эзэний оршихуйд шүүлтэд унахгүйгээр зогсох боломжтой болсон байна.

Исаиа 6-р бүлгээс бид Бурханы ариун байдал бол Түүний дамждаг чанаруудын нэг юм гэдгийг олж хардаг. Энэ чанар нь Түүнийг төгс төгөлдөр, бүрэн дүүрнээр тодорхойлдог. Мөн энэ Түүний бүтээлүүдэд хязгаарлагдмал хэлбэрээр шингэсэн байдаг. Ефес 1:4, Еврей 12:14, 1 Петр 1:15-16 зэрэг олон эшлэл дэх ариун бай гэсэн тушаалын цаад үндэс нь энэ л ариун байдал бүхий Бурханы дамждаг чанарын тухай байдаг. Бид Бурхантай адилхан ёс суртахууны хувьд ариун байхын төлөө уйгагүй хичээх хэрэгтэй. Мэдээж зөвхөн өөрсдийн хүчээр энэ чармайлт маань хэзээ ч амжилт олохгүй. Харин Христ Өөрөө ёс суртахууны хувьд төгс ариун чанартай. Тиймээс бид Түүний дотор байх үед Түүний зөвт байдал биднийх болж, бид төгс ариунд тооцогдож, гэм нүгэл болон завхралаас чөлөөлөгдөх юм.

Ариун гэдэг үгийг тодорхойлох хоёр дахь ойлголт бол Бурханы онцгой үйлчлэлд зориулагдан тусгаарлагдсан хүн эсвэл юмсыг тодорхойлдог явдал юм. Энэ утгаараа бол тэд ёс суртахууны хувьд цэвэр ариун биш ч гэсэн ариун байх боломжтой болж байгаа юм. 1 Коринт 7:14-р эшлэлд Паулын хэлсэн зүйлийг жишээ болгож үзье. Энд:

"Учир нь үл итгэгч нөхөр нь эхнэрээрээ ариусгагдсан байна. Үл итгэгч эхнэр нь итгэгч нөхрөөрөө ариусгагдсан байна" гэжээ (1 Коринт 7:14).

Энэ эшлэлд Паул итгэгч хүн үл итгэгчтэй гэрлэвэл, үл итгэгч эхнэр эсвэл нөхөр нь ариун болно гэсэн байна. Өөр орчуулгуудад үл итгэгч нь "ариусгагдана"

гэсэн байдаг. Үүний гол санаа нь тухайн итгэгч биш хүн хэдийгээр Христийн дотор Бурханы хүчээр ёс суртахуунаараа цэвэр ариун болоогүй ч гэсэн Бурхантай холбоотой болж, Түүний үйлчлэлд ашиглагдахуйц болдог гэсэн санаа юм.

Бурхан ариун бус, төгс биш хүмүүсийг Өөртөө үйлчлүүлэхээр сонгодог гэхээр зарим Христитгэгчдэд их хачин санагддаг байх. Гэхдээ үүнийг сайтар эргэцүүлж бодох юм бол итгэдэггүй хүмүүсийг Бурхан Өөрийн хүслийг гүйцэлдүүлэхийн тулд сонгож байсан олон жишээ Библид бий. Тэдгээрээс хамгийн том жишээ бол элч Иудас бидний Эзэн, Аврагч Есүс Христээс урвасан явдал юм. Иудасыг энэ л зорилгын төлөө сонгосон гэдгээ Есүс Өөрөө хэлсэн байдаг. Түүний урвалтын улмаас Түүний Хүүгийн үнэ цэнтэй үхэл буюу Бурханд зориулсан хамгийн ариун өргөл боломжтой болсон. Тэгвэл Бурхан хорон муу нэгнийг Өөртөө үйлчлүүлэхээр ашиглаж чаддаг юм бол Өөрийг нь хайрладаг ариун хүмүүсийн онцгой үйлчлэлээр Бурхан ямар их алдаршиж болох вэ?

Ингээд ариун байх тухай ойлголт Библид олон талтай байдаг тухай бүгдээрээ үзлээ. Тэгэхээр одоо бид Библид чуулганыг "ариун" эсвэл "ариусгагдсан" болон "ариун хүмүүс" гэсэн үгээр дүрсэлсэн байгааг харах юм бол яг ямар утгаар хэлснийг нь сайтар тунгаах хэрэгтэй гэсэн үг юм. Чуулганы жинхэнэ итгэгчдэд Христийн ариун байдал өгөгдсөн байдаг учраас тэд ёс суртахууны хувьд цэвэр ариун болсон гэдгийг заримдаа Библид онцгойлон сануулсан байдаг. Харин зарим тохиолдолд итгэгч биш ч гэсэн Бурханд онцгойгоор үйлчлэхээр энэ дэлхийгээс сонгогдсон хүмүүсийг хэлсэн байдаг байх нь. Мөн мэдээж заримдаа Бурханд онцгойгоор үйлчлэхээр сонгогдсон жинхэнэ итгэгчдийг бас хэлдэг байна.

Ямар ч тохиолдолд бидний мэдэж байх хэрэгтэй нэг зүйл бол аливаа ариун нэгэн, ариун юмс бүр Бурханд онцгой байдаг явдал юм. Бид Бурханы нэр алдрыг хүндэлдэг учраас дэмий хоосон дууддаггүй. Учир нь Түүний нэр ариун билээ. Ариун Бурханы ариун үг учраас Библийг бид дагадаг. Бид амьдралынхаа талбар бүрд ёс суртахууны хувьд ариун байхыг хүсэж эрмэлзэн, хүндлэн тэмүүлдэг. Учир нь Эзэн биднийг ариун байхаар дуудсан юм. Бид ариун чуулганд харьяалагдаж бас захирагддаг. Ариун зүйл бүрээс бид Бурханы мутрыг олж харж тэдгээрийг дээдлэн хүндэлдэг.

Ингээд ариун байх тухай энэ ойлголтыг мэдэж авлаа. Тэгэхээр одоо энэ ойлголт дээрээ үндэслэн ариун хүмүүс гэж чухам хэнийг хэлдэг тухай авч үзье.

## Хүмүүс

Ерөнхийд нь хэлэхэд Библид хүн төрөлхтөн дундаас Бурханд онцгойгоор үйлчлэхээр сонгогдсон хүмүүсийг "ариун" гэж тодорхойлсон байдаг гэж болно. Жишээ нь, Хуучин Гэрээний Израилыг бүхэлд нь "ариун" хэмээн нэрлэж байсан. Учир нь Бурхан энэ үндэстэнтэй гэрээ байгуулсан байсан юм. Гэтлэл 19:5-6, Дэд Хууль 7:6-9, 28:9, мөн Езекиел 37:26-28 зэрэг эшлэлүүдээс бид энэ тухай харж болно.

Энэ сэдэв Шинэ Гэрээний чуулганд ч мөн үргэлжилсэн байдаг. Жишээ нь, Лук 1:72-р эшлэлд Есүсийг Бурханы ариун гэрээг биелүүлэхээр ирсэн гэж хэлсэн байдаг. Чуулган бол шинэ гэрээний шинэчлэгдэн, сэргээгдсэн Израил гэдэг нь ойлгомжтой байсан учраас чуулганыг ч бас ариун гэжээ. Колоссай 3:12, Еврей 10:29 болон өөр хэд хэдэн эшлэлээс бид яг энэ тухай уншиж болно. Тэдгээрээс нэгийг



жишээ болгон 1 Петр 2:9 дээрх Петрийн Шинэ Гэрээний чуулганд хандан хэлсэн үгийг сонсоцгооё:

"Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм" гэжээ (1 Петр 2:9).

Энэ эшлэлд Петр Хуучин Гэрээний Израилын ариун байдлын тухай хэд хэдэн эшлэлээс эш татан, тэдгээрийг өнөөгийн чуулганд хамааруулан ярьсан байна. Тэрээр Хуучин болон Шинэ Гэрээний чуулган бол нэг л чуулган, нэг л ариун хүмүүсийн нэгдэл гэсэн санааг илэрхийлжээ.

Израилын ч, Шинэ Гэрээний ч чуулганы хүн бүр жинхэнэ итгэгч байгаагүй гэж бид үзсэн шүү дээ. Гэхдээ тэд бүгд Бурханы гэрээний ард түмний буюу Бурхантай гэрээ байгуулсан хүмүүсийн нэгэн хэсэг байсан учраас ариун гэж тооцогдож байв.

Гэрээний харилцаанд буй итгэгчдийн хувьд тэдний ариун байдал нь үл итгэгчдийн ариун байдлаас мэдээж хол илүү байсан. Үл итгэгчид нь зөвхөн Бурханы төлөө тусгаарлагдсан байсан учраас л ариун байсан. Харин итгэгчид нь ийнхүү тусгаарлагдаад зогсохгүй Христ дотор ёс суртахууны хувьд цэвэр хийгээд Бурханд дуулгавартай байсан тул ариун байв. Мэдээж үүний гол зорилго нь гэрээний ард түмэн бүхэлдээ итгэж, хүн бүр Бурханд итгэмжтэй байж, ёс суртахууны хувьд цэвэр ариун амьдралаар амьдрах явдал байлаа.

Ариун хүмүүсийн тухай илүү сайн ойлгоход маань туслах нэгэн арга замыг бид үзэгдэх ба үл үзэгдэх чуулганы хоорондох ялгааны тухай уламжлалт үзэл санаанаас олж хардаг. Тэгвэл одоо үзэгдэх чуулганы тухай бүгдээрээ эхлээд авч үзье.

## Үзэгдэх чуулган

**Үзэгдэх чуулган гэдэг бол бидний харж чадах, харах мэдрэхүйд ил тодорхой харагдаж буй чуулганыг хэлдэг. Үзэгдэх чуулган гэдэг маань дэлхийн эргэн тойронд байгаа, чуулган гэж өөрсдийгөө хэлж байгаа бүх хүнийг хэлнэ. Өнөөдөр Есүс Христэд итгэж, Бурханы үг ба зорилгыг дагадаг гэж хүлээн зөвшөөрдөг дэлхий дээрх урсгал чиглэл бүрийг хэлнэ. Үүнд олон янзын урсгал чиглэл багтах бөгөөд ямар нэгэн урсгал чиглэлд хамаардаггүй ч өөрсдийгөө Христийн дагалдагч гэдэг бүхэн ч багтана гэсэн үг.**

-Др. Марк Л. Страус

Ямар ч үед үзэгдэх чуулганд зүрх сэтгэлийн байдлаас үл хамааран чуулганы хэсэг болсон хүн бүр багтдаг. Үзэгдэх чуулганы нэгэн хэсэг болох хэд хэдэн арга зам бий. Хүмүүс Шинэ Гэрээнд баптисм хүртэх, Хуучин Гэрээнд хозлуулах замаар Бурханы гэрээнд багтдаг байсан. Мөн тэд Христэд итгэдэг мөн итгэлээ хүлээн зөвшөөрсөн байж болно. Албан ёсны гишүүнчлэл шаарддаггүй эсвэл баптисм гэх мэт гэрээний баталгаажуулах ёслол хийдэггүй чуулгануудад чуулганаа сургаал номлолд захирагддаг бол тэд гэрээний гишүүд гэж тооцогддог. Мөн 1 Коринт 7:14-р эшлэлд Паулын зааснаар итгэгч эцэг эх эсвэл хань ижилтэй байж болно гэжээ.

Жишээ нь, Хуучин Гэрээнд Израил үндэстэн бүхэлдээ чуулганы нэгэн хэсэг байсан. Мэдээж тэд бүгд авралд хүргэх итгэлтэй байгаагүй. Гэхдээ тэд ямартай ч үндэстний нэг хэсэг гэдэг утгаараа чуулганд багтаж чадсан юм. Мөн үүнээс гадна Эхлэл 17-р эшлэлд Бурханы зааварчилснаар тэдний эрэгтэйчүүд нь хозлууулж Бурханы гэрээнд нэгдсэн гэдгээ баталгаажуулдаг байв.

Шинэ Гэрээ ч бас үүнтэй төстэй. Чуулганы цугларалтад хамрагддаг хүн бүрийг чуулганы нэгэн хэсэг гэж тооцдог. Үүнд итгэлээ хүлээн зөвшөөрсөн, баптисм хүртсэн хүн бүр, мөн тэдний хань ижил, үр хүүхдүүд төдийгүй тэдний гэрийн зарц, боолууд хүртэл багтдаг байсан. Тухайлбал, Паул олон янзын чуулган руу захидал бичихдээ тэдгээр чуулгантай холбоотой хүн бүрд хандан бичдэг байсан. Христитгэгчдийг өөрсдийнхөө итгэлийг шалгаж байх тухай бичихдээ Паул чуулгануудад итгэдэггүй хүмүүс байхыг мэдэж байсан. 2 Коринт 13:5 гэх мэт эшлэлээс бид энэ тухай харж болно. Матай 13:24-30-р эшлэлд Есүс буудай ба үрийн сүүлийн тухай сургаалт зүйрлэл ярихдаа үүнтэй адилхан санааг хэлсэн. Мөн Илчлэл 2-3-р бүлэг дэх чуулгануудад хандсан захидалд Есүс тэднийг эцсээ хүртэл тэсээрэй хэмээн уйгагүй зоригжуулсан байдаг. Мөн Еврей 6:4-8 болон 10:29 гэх мэт багц эшлэлүүдэд шинэ гэрээг зөрчихийн эсрэг анхааруулсан зүйлсэд үүнтэй адил санааг онцолсон нь бий.

Нэг жишээ болгож Еврей 10:29-р эшлэлд юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

"Тэгвэл Бурханы Хүүг уландаа гишгэж, өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн тооцсон, нигүүлслийн Сүнснийг доромжлогч нь хэр хүнд шийтгэл эдэлбэл зохино гэж та нар бодож байна?" гэжээ (Еврей 10:29).

Энэ эшлэлд Еврей номыг бичсэн хүн Бурханы гэрээнд нэгдэж, ариусгагдсаны дараа ч гэсэн Христийг үгүйсгэх боломжтой гэдгийг өгүүлдэг. Энэ бүлгийн төгсгөлд шийтгэл нь тамд үүрд мөнх зовж шаналах юм гэдгийг тодорхой хэлсэн.

**Есүсийн зааснаар үзэгдэх чуулганд "буудай ба үрийн сүүл" үргэлж хамт байх болно гэдгийг санаж байх нь чухал юм. Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг хүмүүс бий. Эсвэл гаднаасаа тийм юм шиг харагддаг хүмүүс ч бас байна. Яг л Есүсийн үнэнч дагалдагчид нь Иудаcтай хамт байсантай адил юм. Паулын дагалдагч нарын дунд Дем бас хамт байсны адил бидний дунд ч байсаар байх болно.**

**-Др. Доналд С. Витней**

Үзэгдэх чуулганд олон янзын хүн байдаг гэдэг нь бид чуулган дахь үл итгэл, алдаа зөрчлөөс үргэлж сэргийлж байх ёстой гэсэн үг юм. Гэхдээ ямар ч үед чуулганы үйлчлэлд итгэдэггүй хүмүүс оролцож байсан ч чуулганы ариун байдал алдагдахгүй. Тиймээс бид ариун зан үйл, Бурханы ариун ёслолуудыг хүндлэн дагадаг. Мөн Филиппой 1:14-18-р эшлэлд Паулын заасанчлан чадваргүй эсвэл хоёр нүүртнүүд заасан ч Бурханы Ариун Үгийг бид эрхэмлэдэг. Чуулганы ариун байдал бидэнд чуулганыг Бурханаас дээгүүр тавихгүй байхыг, мөн Бурхан хүний гэм нүгэл,

итгэлгүй байдлаас үл хамааран чуулганыг үр нөлөөтэйгөөр ашигладаг гэдэгт итгэлтэй байхыг сануулдаг юм.

Бид үзэгдэх чуулганы тухай тодорхой ойлголттой боллоо. Одоо бүгдээрээ үл үзэгдэх чуулганы талаар авч үзэцгээе.

## Үл үзэгдэх чуулган

**Үзэгдэх чуулган бол дэлхийн хаа сайгүй, газар орон нутгуудад Ням гараг бүр цуглардаг итгэгчдийн цугларалт бөгөөд энэ нь тодорхой хэмжээгээр итгэлийн алхмыг хийсэн хүмүүсээс бүрддэг. Энэ бол хамтдаа уулзаж баптисм болон Эзэний зоог гэдэг хоёр ариун ёслолыг үйлдсэнээр Бурханы үзэгдэх чуулганы идэвхтэй гишүүд гэдгээ таниулдаг газар билээ.**

**-Рев. Др. Симон Виберт**

Үзэгдэх чуулганд Бурханы гэрээний ард түмний нэгэн хэсэг болсон хүн бүр багтдаг бол, үл үзэгдэх чуулган нь зөвхөн Христтэй нэгдэн аврагдсан хүмүүсээс бүрддэг. Тийм ч учраас заримдаа "жинхэнэ чуулган" ч гэж нэрлэдэг. Бид үл үзэгдэх чуулганыг үзэгдэх чуулган доторх арай цөөн хүнтэй бүлэг гэж төсөөлж болох юм. Ерөнхийдөө бид үзэгдэх чуулганы бүхий л хүмүүст жинхэнэ аврагдсан хүмүүс мэт хандаж, тийнхүү итгэж найддаг. Гэвч үнэндээ Дуулал 44:21, Үйлс 15:8 гэх мэт Библийн эшлэлүүдэд бичсэнчлэн зөвхөн Бурхан л хүний зүрхийг мэддэг билээ. Тиймээс түүхийн яг энэ үед зөвхөн Бурхан үл үзэгдэх чуулганд хэн хэн байгааг тодорхой сайн мэднэ. Бид дэлхийд амьдарч буй тухайн цаг үеийнхээ оршин буй үл үзэгдэх чуулганд л гол анхаарлаа хандуулдаг. Хэдий тийм ч үл үзэгдэх чуулганд Христийн газар дэлхий дээрх үйлчлэлээс өмнөх ба хойших итгэгч хүн бүр багтдаг гэдгийг ойлгох нь чухал.

Библи үл үзэгдэх чуулганаас илүү үзэгдэх чуулганд голчлон хандсан байдаг. Гэвч энэ нь аврагдсан эсэхээ шалгах хэрэгтэйг уншигчдадаа сануулдаг. 1 Коринт 5, 1 Тимот 1:19-20 зэрэг эшлэлүүд энэ тухай маш ойлгомжтой тайлбарласан. Илчлэл 2-3-р бүлэг дэх чуулгануудад хандсан зарим захидлууд тийм ч өөдрөг байдаггүй шүү дээ. Ерөнхийдөө Бичвэрийн бичээчид уншигчид нь Бурханд итгэж, найдан, Түүнд дуулгавартай байхыг хүсэж байсан нь лавтай. Хүн бүр баттай итгэж, үзэгдэх чуулган бүхлээрээ үл үзэгдэх чуулган байх нь гол зорилго мөн.

Есүс эргэн ирээд чуулганаа бүрэн дүүрэн ариусгана. Үл итгэгчдийг чуулганаасаа таслан хаяж, тийнхүү үл үзэгдэх чуулган нь үзэгдэх чуулган гэгдэх юм. Энэ тухай бид Матай 7:21-23, мөн 13:24-30, 1 Коринт 3:12-15, мөн 1 Петр 4:17-19 зэрэг эшлэлүүдээс харж болно. Гэхдээ тэр цагийг хүртэл үзэгдэх чуулганд байгаа хүмүүсийн жинхэнэ итгэлийг зөвхөн Бурхан л баттай мэдэх юм.

Үзэгдэх чуулганы дотор үл үзэгдэх чуулган байгаа гэдэг үнэн нь өөрийгөө Христитгэгч гэдэг хүн бүрд маш чухал ач холбогдолтой. Хамгийн чухал ач холбогдлуудын нэг нь чуулган Сайнмэдээг тогтмол сонсох шаардлагатай байдаг явдал юм. Чуулганд итгэж амжаагүй хүмүүс байгааг бид мэднэ. Энэ нь чуулганы гишүүн байх нь авралын баталгаа болохгүй гэсэн үг. Тийм учраас бид авралын Сайнмэдээг зөвхөн өөрсдөдөө биш бусдад ч бас зааж, номлохоо зогсоож болохгүй. Сүм чуулганд маань явж байгаа итгэж амжаагүй хүмүүсийг Христ уруу урьж, үл

үзэгдэх чуулганы нэгэн хэсэг болох боломжийг өгч чадсан уу гэдгээ бид шалгаж байх хэрэгтэй.

Элч нарын тунхагт чуулганыг ариун гэж батлан тунхагласан нь чуулган Бурхантай гэрээ байгуулсан гэсэн утгыг илэрхийлдэг. Мөн энэ бол Бурханы үйлчлэлд зориулагдан тусгаарлагдсан Бурханы онцгой хүмүүс гэсэн үг. Хэдийгээр чуулганы итгэгчид Христийн цэвэр ариун байдалд нуугдан халхлагддаг ч чуулганы туйлын зорилго бол ёс суртахууны цэвэр ариун байдалд хүрэх юм гэсэн санааг бас энд хэлж байна. Мэдээж бид Эзэнийхээ тушаалыг тууштай сахихын төлөө явахдаа гэм нүглээсээ ч ариусгагдаж байдаг. Мөн Бурханы бидэнд төлөвлөсөн тэр л төгс төгөлдөр ариун байдалд бага багаар дөхөж байдаг билээ.

Ингээд бид чуулганыг ач холбогдолтой, эрх мэдэлтэй болгодог чуулганы хүлээн зөвшөөрлийн тухай мөн чуулган бол Бурханы хувьд ариун юм гэдэг ойлголтыг авч үзлээ. Одоо тэгэхээр бид гурав дахь сэдэв болох даян дэлхийн буюу даяар чуулганы тухай үзэхэд бэлэн боллоо.

## ДАЯАР ЧУУЛГАН

---

Бид "католик" буюу даяар гэдэг үгийг гурван хэсэгт хуваан үзэх болно. Нэгдүгээрт, бид "католик" гэдэг үгийн тодорхойлолтыг авч үзнэ. Хоёрдугаарт, үзэгдэх чуулганы даяар чанарын талаар судална. Гуравдугаарт, бид үл үзэгдэх чуулганы даяар чанарын тухай харах болно. Ингээд "католик" гэдэг үгийн утгыг эхлээд үзэцгээе.

### Тодорхойлолт

Өмнөх хичээлээр үзсэнчлэн католик буюу даяар гэдэг үг нь даян дэлхийн буюу бүх чуулганы, бүх Христитгэгчид гэсэн утгатай. Энэхүү "католик" гэдэг үг нь католикүс гэх латин үгийн орчуулга бөгөөд энэ нь Грек хэлний ката гэдэг утвар үг, мөн "бүх" эсвэл "бүрэн" гэсэн утгатай холос гэдэг тэмдэг үгнээс гаралтай юм. Энэ үг нь Ромын Католик сүмийг хэлээгүй гэдгийг анхаараарай. Харин Христийг итгэмжтэйгээр дагадаг бүх чуулганы нэгдэл гэсэн утгыг илэрхийлж байгаа үг юм.

Энэ цуврал хичээлийн эхний хичээлүүдээр эртнээс баптисм хүртэхдээ уншдаг байсан тунхгаас өнөөгийн Элч нарын тунхаг хөгжин бий болсон тухай үзсэн шүү дээ. Тэдгээр анхны тунхгууд бичигдэж байх цаг үед дэлхий даяарх чуулган нь бүгдийг хамарсан нэг засаглал дор хараахан нэгдээгүй байсан. Тэгэхээр Элч нарын тунхагт чуулганы даяар нэгдмэл байх тухай заахдаа бүх Христитгэлт чуулгануудыг нэгтгэсэн байгууллагын тухай хэлээгүй гэсэн үг. Харин тогтолцооны онцлог ялгаатай байдлаас үл хамаарах, жинхэнэ Христитгэлт чуулгануудад оршдог Ариун Сүнсний нэгдлийн тухай хэлсэн байна. Түүхийн энэ цаг үед "католик" гэдэг үгийг их өргөн утгаар ашигладаг байсан. Энэхүү "чуулган" гэдэг үгийг Христитгэлийн чуулган бүрд хамааруулж хэлэхдээ ашигладаг байсан байна.

Коринт 1:2-р эшлэлд Паулын хэлсэн үгэнд ч энэхүү санаа явж байдаг. Тэрээр захидалдаа энэ тухай өгүүлдэг. Энд:

"Коринт дахь Бурханы чуулганд болон хаа сайгүй Эзэн Есүс Христийн маань нэрийг дуудагчдын хамт ариун хүмүүс байхаар дуудагдаж... (Эзэн бол тэднийх болон биднийх юм.)" гэжээ (1 Коринт 1:2).

Энд Паул Коринт дахь бүхий л цуглаануудыг “Коринт дахь... чуулганд” гэсэн нь хаана амьдарч байгаагаас үл хамааран Христийн нэрийг дуудсан бүх хүмүүсийг багтаасан томоохон чуулганы нэг хэсэг гэдгийг онцолсон хэрэг байжээ.

Гуравдугаар зууны дунд үед Картежийн Киприан нь чуулганыг тодорхойлохдоо бишоп, санваартнуудын үүргийг ихэд онцолж эхэлсэн. Тэрээр 68-р захидалдаа:

**"Тэд бол санваартнуудтай нэгдсэн хүмүүсийн Чуулган юм... Даяар нэгдмэл Чуулган нь хуваагдалгүй, бутралгүй, харин санваартнаар бие биетэйгээ салшгүй холбоотой болсон нэгдэл юм" гэжээ**

Киприаны хувьд чуулганы нэгдэл нь санваартнуудын нэгдэл ба тэдний үйлчлэл дээр суурилдаг гэж үзсэн. Энэ үзэл улам бүр газар авахын хэрээр Христитгэгчид чуулганы нэгдлийг удирдлагын нэгдэл гэж итгэн дагаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл чуулганы бишопууд, санваартнууд дэлхий даяар тархсан тул чуулган бол дэлхийн хаа сайгүй орших нэг л байгууллага гэсэн үг байлаа.

Энэ үзэл санааны хувьд ч гэсэн "католик" гэдэг үгээр бүхнийг хамарсан, Христийн нэрээр дуудагдсан, чуулганы уламжлалт сургаал номлолыг дагадаг чуулган бүрийг, хүн бүрийг хамруулсан гэсэн утгыг илэрхийлж байв.

Гэсэн ч хожим нь чуулган олон хэсэгт хагаран бутарсан. Жишээ нь, МЭ 1054 онд Ромын Католик сүм Зүүний Ортодокс чуулгануудаас салж, Зүүний Ортодокс чуулганууд ч Ромын Католик сүмээс харилцаагаа тасалсан.

Энэ цагаас чуулганууд "католик" гэдэг үгийг онцгой шинэ утгаар ашиглаж эхэлсэн. Тэд өөрсдийн чуулганыг католик буюу даяар чуулган гэсэн нь өөрсдийгөө л цорын ганц хүчин төгөлдөр чуулган хэмээн тодорхойлж, бусад сүм чуулгануудыг буруушааж байв.

Хожим нь 16-р зууны Шинэчлэлийн үед ихэнх Протестант чуулганууд өөр үзэлтэй болсон. Хамгийн гол нь тэд тунхгийн анхны утга санааг чухалчилж, "католик" гэдэг үгийг даяар гэдэг анхны утгаар нь ашиглаж эхэлсэн. Христийн удирдлага дор бүх Христитгэлийн чуулгануудыг нэгтгэдэг Сүнсний нэгдлийн тухай Бичвэр болон Элч нарын тунхгийн аль алиных нь дэмждэг санааг Протестант чуулганууд ч итгэн дагаж эхэлсэн. Зөвхөн чуулганы удирдлага засаглалд төвлөрөхгүйгээр, урсгал чиглэл бүрийн хувь нэмрийг алдагдуулахгүйгээр энэ нэгдлийг сахин хамгаалж болно гэдгийг тэд ойлгосон.

Орчин үеийн дэлхийд чуулганы даяар чанарыг хүлээн зөвшөөрнө гэдэг нь Элч нарын тунхаг дахь онол номлолуудыг дагадаг чуулган бүрийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм. Итгэмжит чуулган бүрийн бүхий л Христитгэгч Христийн гэрээний удирдлага дор байдаг бөгөөд жинхэнэ итгэгч бүр Ариун Сүнсний бэлэг авьяасаар ерөөгддөг. Тийм учраас бид итгэмжит чуулган бүрийн жинхэнэ Христитгэгч бүрд ирдэг бэлгүүдийн ашиг тусыг хүртэж, чадах чинээгээрээ хамтдаа үйлчлэхийг хүсэн тэмүүлж байх нь зүйтэй.

Бид "католик" буюу даяар хэмээх үгийн тодорхойлолтын тухай үзлээ. Тэгэхээр одоо бүгдээрээ үзэгдэх чуулганыг яагаад "католик" буюу даяар гэж нэрлэх ёстойг одоо үзье.

## Үзэгдэх даяар чуулган

Даяар чанарын талаарх ойлголтоо үзэгдэх чуулганы тухай ойлголттойгоо хамтатган харвал үзэгдэх даяар чуулганыг дараах байдлаар тодорхойлж болох юм.

**Энэ нь -дэ Христийн удирдлага дор Бурханы гэрээнд нэгдсэн дэлхий даяар буй бүх хүний нөхөрлөл.**

Мэдээж энэ нөхөрлөл бол чуулганы засаглал дор биш харин нэг Сүнс доторх нөхөрлөл юм. Үнэндээ бүх Христитгэлийн чуулганыг нийтэд нь захирдаг нэг урсгал чиглэл гэж байхгүй. Тэгэхээр үзэгдэх чуулганы нэгдэл бол чуулган бүр нэг л Бурханы гэрээнд нэгдэж, нэг л Христийн гэрээний дагуух удирдлага дор байдаг гэдэг үнэн дээр үндэслэсэн байдаг гэсэн үг юм.

Түүхийн туршид үзэгдэх чуулган нь олон арга замаар даяар чанараа хадгалсаар байсан. Зарим нэг уламжлалд чуулганы засаглалаар дамжуулан хадгалж байв. Чуулган өсөж үржихийн хэрээр өргөжин тэлж, өмнө нь үйлчилж байсан хүмүүс шинээр үйлчлэх хүн бүрийг гар тавин томилдог байсан.

Харин протестантууд чуулганы даяар нэгдмэл чанар нь чуулганы үйлчлэгч, санваартнуудыг томилох залгамж холбооноос илүү бидний Христэд итгэх итгэл болон Ариун Сүнсний үйл хэрэгт оршдог гэдгийг ихэд чухалчлах болсон. Өөрөөр хэлбэл Сүнсний нэгдэл байгаа газар бүрд, Христийн нэрээр цуглах Бурханы гэрээнд нэгдсэн хүмүүс байгаа ямар ч газар шинэ чуулган үүсэн бий болох боломжтой ажээ. Сүнсний нэгдэл дотор, Христийн удирдлага дор Бурханы гэрээнд нэгдсэн хүмүүсийн байгаа газар бүрд чуулган оршдог учраас үзэгдэх чуулган бол даяар юм гэдэг үзлийг протестантууд тууштай баримталдаг болсон.

Өнөөгийн Христитгэгчдэд тулгардаг түгээмэл бэрхшээлүүдийн нэг бол ямар чуулганыг Христийн даяар чуулганы нэгэн хэсэг гэж хүлээн авах вэ гэдгээ мэдэх явдал юм. Дэлхийн хаа сайгүй Христитгэлийн гэж өөрсдийгөө хэлдэг олон янзын сүм чуулганууд байдаг. Тиймээс сайн санаат Христитгэгчид хоёр туйлын аль нэгийг л сонгох нь түгээмэл. Тэд нэг бол Христитгэлийн гэсэн чуулган бүрийг гараа дэлгэн хүлээн авдаг. Нэг бол чуулган эсвэл урсгал чиглэлийн талаарх явцуу тодорхойлолтод нь таарч тохироогүй бүгдийг хасаж орхидог.

Энэ бэрхшээлийг шийдэх тустай арга бол чуулганы уламжлалт гурван шинж тэмдэг юм. Эдгээр шинж тэмдгүүдийг Жон Нокс 16-р зууны үед Шотландад анх тодорхойлон гаргаж ирсэн ч үнэндээ тухайн цаг үеийн олон Протестант чуулганы үзэл бодлын төлөөлөл байсан юм. Ялангуяа эдгээр шинж тэмдгүүд нь үзэгдэх даяар чуулганд хамаарах жинхэнэ чуулганыг хуурамч цуглаанаас ялгахад тустай байдаг.

**Чуулганы шинж тэмдгүүд нь чуулганыг хаана байгааг олж мэдэхэд зайлшгүй чухал байдаг. Учир нь хэн ч өөрийгөө чуулган гэх амархан шүү дээ. Теологийн томоохон хямрал зөрчлийн үед, тухайлбал 16-р зууны Шинэчлэлийн үед "Жинхэнэ чуулганыг**

хаанаас олох вэ?" гэдэг асуулт урган гарсан юм. Тиймээс шинэчлэгчид, жишээ нь, "Энэ бол хаяг биш, энэ бол барилгын архитекторын загварын тухай биш, харин энэ бол Бурханы үгийн сургаал номлол юм" гэх мэтээр чуулганы шалгууруудыг тун нарийн няхуур тодорхойлж өгчээ. Хаана Бурханы үг үнэн зөвөөр тунхаглагдаж байна, тэнд чуулган байна. Хаана тосолгоо томилгоо, ариун ёслолуудыг зүй зохистой үйлдэж байна, тэнд чуулган байна. Харин хамгийн сүүлийн шалгуур нь чуулганы сахилгажуулалт юм. Сахилгажуулалт үгүй бол чуулганы ариун байдал алдагдаж, үүнээс болж яваандаа чуулганы үнэн зөв ба жинхэнэ чанар нь үгүй болно гэсэн үг юм.

-Др. Р. Алберт Мохлер, Жр.

Үзэгдэх даяар чуулганы эдгээр гурван шинж тэмдгүүдийг нэг нэгээр нь авч үзэцгээе. Бурханы үг тунхаглагдаж байх ёстой гэсэн эхний шалгуураас эхэлцгээе.

Бурханы үгийг эзэмших, тайлбарлах, хэрэгжүүлэх, мөн тунхаглах онцгой эрхтэй чуулган эсвэл урсгал чиглэл гэж үгүй. Зарим чуулган эсвэл урсгал чиглэлүүд өөрсдийгөө Бичвэрийг тайлбарлах болон заах онцгой эрхтэй гэж үздэг. Харин зарим нь Библийг бусдаас илүү үнэн зөвөөр ойлгох онцгой гэгээрэлд хүрсэн гэж өөрсдийгөө үздэг. Гэхдээ Үгийг тунхаглахыг оруулаад чуулганы шинж тэмдгүүдийг төгс төгөлдөр тодорхойлж чадах ямар ч чуулган байхгүй. Бурхан Библийг үзэгдэх чуулганд өгсөн. Мөн Бурхан Библийг ойлгоход нь туслах Ариун Сүнснийг ч өгсөн. 1 Тимот 3:15, Еврей 4:11-13, мөн 6:4-6 зэрэг эшлэлүүдээс бид энэ тухай харж болно. Үүнээс гадна Матай 28:20, 1 Тимот 4:17, мөн 2 Тимот 2:15 болон 3:14-17 эшлэлүүдэд бичсэнээр Бурханы үгийг уншиж, ойлгож, зааж сургахыг Бичвэрт уриалсан байдаг.

Чуулганы хоёр дахь шинж тэмдэг бол баптисм болон Эзэний зоогийн ёслолуудыг зүй зохистойгоор хэрэгжүүлэх явдал юм. Тэдгээр ёслолууд нь зөвхөн зарим нэг урсгал чиглэлд биш, харин үзэгдэх чуулганд бүхэлд нь хамаатай.

Ариун ёслолуудыг Бичвэрийн дагуу хэрэгжүүлэх нь үзэгдэх чуулган дахь үүрэг хариуцлага бөгөөд эрх мэдэл юм. Матай 28:19 дээрх Агуу Захирамжид, мөн 1 Коринт 1:13-17-р эшлэл дэх Паулын сургаалд баптисм хийхийг тушаасан байдаг шүү дээ. Бид мөн Лук 22:15-20 дээрээс Эзэний зоогийн талаарх Есүсийн зааврыг олж уншдаг. Энэ нь Түүний бүх хаанчлалын төлөө, Түүний гэрээнд нэгдсэн бүх хүнд зориулсан гэдгийг тодорхой хэлсэн байдаг. Эдгээр эшлэлүүдийн улмаас л ихэнх Протестант чуулганууд бусад чуулганууд болон урсгал чиглэлүүдийн ариун ёслолуудыг хүлээн зөвшөөрдөг.

Үзэгдэх даяар чуулганы гурав дахь шинж тэмдэг бол чуулганаас хөөх гэх мэт, чуулганы албан ёсны сахилгажуулалт байдаг.

Чуулганаас хөөх гэх мэт сахилжуулалтанд дуртай Христитгэгч хүн байхгүй нь мэдээж. Энэ нь чуулгануудыг албан ёсны сахилгажуулалтыг хэрэгжүүлэхээс зайлсхийхэд хүргэдэг. Мэдээж Матай 13:24-30-р эшлэл дэх буудай ба үрийн сүүлний тухай сургаалт зүйрлэлээс бид тэвчээртэй байх нь ч мөн Библийн үндэслэлтэйг харж болно.

Гэсэн ч сахилгажуулалт байх ёстой. Хэн нэгэн хүний гэм нүгэл маш их хор хохирол учруулах, ялангуяа чуулган болон чуулганы нэр төрд уршиг тарих тохиолдол байдаг. Тиймээс үүнийг зайлшгүй сахилгажуулалтаар л шийдвэрлэх



хэрэгтэй байдаг. Ийм тохиолдолд сахилгажуулалт нь чуулганыг хамгаалж, гэмд унасан нэгнийг гэмээсээ эргэхэд туслах зорилготой юм. Албан ёсны сахилгажуулалтын Библийн үндсийг Матай 16:19, 18:18, Иохан 20:23, мөн Тит 3:10 зэрэг эшлэлээс харж болно. Харин үүнийг хэрэгжүүлсэн тухай бид 1 Коринт 5:1-13 зэрэг эшлэлээс харж болдог. Үзэгдэх чуулган бүхэлдээ Христийнх бөгөөд газар дэлхий дээр Түүнийг төлөөлдөг. Тиймээс үзэгдэх чуулганы хэсэг бүр Христийн хүмүүсийг хамгаалж, сахилгажуулалтыг зөв зүйтэйгээр хэрэгжүүлэх замаар Түүний алдар хүндийг хадгалж явах нь чухал билээ.

Чуулганы шинж тэмдгүүд нь өнөөдөр ч бидэнд чухал хэвээр байгаа. Чуулган маань Христийн удирдлага дор, Бурханы гэрээн дотор байдаг үзэгдэх даяар чуулганы хэм хэмжээнд хүрч байгаа эсэхийг мэдэхэд маань эдгээр шинж тэмдгүүд бидэнд тусална. Мөн эдгээр нь чуулганы дайсан ба хуурамч хүмүүсийг ялган танихад тусалдаг. Тийнхүү бид тэдгээр бүлэг хүмүүсээс хол байхыг итгэгчдэд анхааруулан, тэд Эзэн болон Түүний Сайнмэдээг төлөөлж чадахгүй гэдгийг олон түмэнд тунхаглах юм. Мөн эдгээр шинж тэмдгүүд нь биднийг үйлчлэлд гар бие оролцохдоо урсгал чиглэлд баригдахгүйгээр ажиллахад зоригжуулдаг. Христийн бие хэзээ ч чуулган болон урсгал чиглэлээр хязгаарлагддаггүй, харин Христийн Сайнмэдээ тунхаглагдсан газар бүрд дэлхий даяар тэлдэг гэдгийг бид ойлгож чадвал үзэгдэх чуулганы нэгэн хэсэг болсон хүн бүрийг хүлээн авах урам зоригтой болох болно.

Ингээд бид үзэгдэх чуулганы даяар чанарын тухай үзлээ. Тэгвэл одоо үл үзэгдэх чуулган нь мөн даяар буюу даян дэлхийн чанартай байдаг тухай үзэцгээе.

## Үл үзэгдэх даяар чуулган

Бид даяар чанарын талаарх ойлголтоо үл үзэгдэх чуулганы тухай ойлголттойгоо хамтатган харвал үл үзэгдэх даяар чуулганыг бид дараах байдлаар тодорхойлж болно. Энэ нь Христтэй нэгдэж авралд хүрсэн бүх үеийн бүх хүмүүсийг хэлнэ. Үл үзэгдэх чуулган бол үзэгдэх чуулганы нэгэн хэсэг гэж бид өмнө нь үзсэн. Тиймээс үл үзэгдэх чуулган дахь хүн бүр Бурхантай гэрээнд нэгдэж, Христийн удирдлага дор байдаг гэсэн үг юм. Гэхдээ үл үзэгдэх чуулганыг ялгаж танихын тулд бид үзэгдэх чуулганаас яг ямар ялгаатай вэ гэдгийг тодорхойлоход анхаарлаа хандуулцгаая.

Үл үзэгдэх чуулганы даяар чанарыг авч үзэх олон арга зам бий ч бид эдгээрээс хоёрыг нь л авч үзнэ. Нэгдүгээрт, нэг л Аврагч бий тул үл үзэгдэх чуулган бол даян дэлхий чанартай юм. Хоёрдугаарт, биднийг Аврагч уруу хөтөлж чадах ганц л үнэн итгэл үнэмшил буй тул үл үзэгдэх чуулган нь даян дэлхийн чуулган билээ. Ингээд нэг л Аврагч бий гэсэн эхний санааг одоо харцгаая.

## Нэг Аврагч

Есүс Христ бол хүн төрөлхтний цорын ганц Аврагч гэдгийг Бичвэрт тодорхой заасан байдаг. Тэр бол биднийг аврах хүч чадалтай цорын ганц Нэгэн байсан ба цорын ганц нь байх болно. Энэ тухай Үйлс 4:12-р эшлэлд Петр өгүүлсэн байдаг. Тэрээр:



"Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бидний аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүнд эс өгөгдөв" гэжээ (Үйлс 4:12).

Есүс Христ үргэлж хүн төрөлхтөнд заяасан цорын ганц Аврагч нь байсаар ирсэн. Их Эзэн маань Өөрийнхөө талаарх энэхүү үнэнийг Иохан 14:6-р эшлэлд тунхаглан зарласан байдаг. Тэрээр:

"Зам, үнэн, амь бол Би байгаа юм. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй" гэдэг (Иохан 14:6).

**Яагаад зөвхөн Есүс л биднийг аварч чадах юм бэ? Тийм ээ, Аврагч нь төгс хүн төдийгүй төгс Бурхан байх ёстой байсан юм. Тэгэхээр бидний оронд, бидний өмнөөс, бидний төлөө золиос болохын тулд Есүс л төгс төгөлдөр хүн байх ёстой байв. Энэ шаардлагад хүрч чадах цорын ганц нэгэн бол яах аргагүй Есүс юм. Бурхан Давидын хургыг тослогдсон Нэгэн, Бурханы Мессиа болгохоор тогтоон томилж, авралын түүхийн туршид үүний төлөө л бэлтгэсээр ирсэн билээ. Есүс бол Давидын байр суурийг залгах, түүний дараа ирэх Агуу Хаан байсан. Тиймээс Хуучин Гэрээ нь бүхэлдээ Есүсийн ирэлтэд биднийг бэлтгэж байсан гэсэн үг. Тэгэхээр Есүс бол Өөрийн хүмүүсийг гэм нүглээс бүрэн гүйцэд аврах бүхий л шалгуурыг хангаж чадах цорын ганц Нэгэн мөн.**

**-Др. Жон М. Фрэйм**

Есүс бол Пресбетериан, Баптист, Англикан, Методист, Лүтериан, Ромын католик, Зүүний ортодокс гээд бусад бүх үзэгдэх чуулганы Аврагч мөн. Аврагдсан хүн бүр нэг Христ, нэг л Аврагчтай нэгдсэн учраас зөвхөн нэг л үл үзэгдэх чуулган бий. Тэрээр бидний нэгдлийн эх үндэс юм. Тэр Өөрөө хуваагдалгүй, нэг учраас бид ч бас хуваагдалгүй нэг билээ.

Үл үзэгдэх чуулган бол даяар буюу даян дэлхийн чанартай гэдэг үнэнтэй холбоотой хоёр дахь санаа бол биднийг Христ уруу хөтөлдөг ганц үнэн итгэл бишрэл бий гэдэг нь юм.

## **Нэг итгэл бишрэл**

Христитгэл бол зөвхөн аврагдах арга замын тухай биш юм. Харин Бурхантай гэрээний харилцаатай болох тухай юм гэдгийг ойлгох нь чухал. Өөрөөр хэлбэл бусад шашнаас ялгаатай нь Христитгэл нь зөвхөн авралд хүрэх арга замыг гол үндэс болгодоггүй. Харин энэ бол Бурхан ба Түүний хүмүүсийн хоорондын харилцаа юм. Тийм ээ, итгэл нь биднийг Бурхантай зөв харилцаатай болоход амин чухал зүйл мөн. Харин хамгийн гол асуулт бол: Та Бурханы өмнө хэн байх вэ? Та Бурханы хаанчлалын итгэмжтэй иргэн мөн үү? Бурхан таныг хараад Христийн цусаар хучигдсан нэгнийг хардаг уу? Эсвэл та Түүний дайсны хаанчлалын иргэн үү? Та Бурханы өмнө өөрийн хичээл зүтгэлээр зогсох нэгэн үү? Таны гэм нүглийн шийтгэлийг хэн төлөх ёстой вэ?

Харамсалтай нь, хуурамч шашинд байгаа бүхэн дайсны хаанчлалын гишүүд юм. Тэд Бурханы гэрээний ард түмэнд багтахгүй. Тиймээс тэд Христийнх биш бас Христийнх байх боломжгүй. Зөвхөн Христитгэл л биднийг Аврагч уруу хүргэж чадна. Үүний улмаас л Библийн дагуух Христитгэл нь өөр бусад шашныг хэдий сайн санаа, зорилготой байсан ч тэдгээрээр аврагдах боломжгүй хэмээн үгүйсгэдэг юм.

**Христитгэлийн биш олон шашин байдгийг бид мэднэ шүү дээ. Заримдаа тэдний хэмжээ болон нөлөөнөөс хамааран "дэлхийн томоохон шашнууд" гэж нэрлэх явдал байдаг. Хэрэв хэн нэгэн хүн Христитгэгч биш ч гэсэн тэдгээр шашнуудын аль нэгийг шүтэж, сургаал номлолыг нь даган, шашиндаа үнэнч байвал яах вэ? Тэд Христийг хүлээн зөвшөөрдөггүй, магадгүй Есүсийн тухай хэзээ ч сонсоогүй бол тэнгэрийн улс руу явах болов уу гэдэг асуулт гарч ирдэг шүү дээ. Тийм ээ, Библид энэ тухай тодорхой хэлсэн байдаг. Иохан 14:5-р эшлэлд Есүс яг ийм нөхцөл байдалд тун тодорхой хариулт өгсөн. Тэрээр Өөрийгөө "Би бол зам, Би бол үнэн, Би бол амь" гэж хэлээд үүнийгээ илүү ойлгомжтой болгож "хэн ч надаар дамжихгүйгээр Эцэгт хүрэхгүй" гэж хэлсэн байдаг.**

-Др. Доналд С. Витней

**Бурханы нийтлэг нигүүлслийн ачаар ямар ч шашинтай байсан хамаагүй хүмүүсийн амьдралд сайн сайхан зүйлс олон байдаг. Гэвч хүмүүсийн амьдралд хорон муу зүйлс ч их бий. Хэрэв бид Бурхан ямар цэвэр ариун, харин бид гэм нүгэлд унасан гэдгээ ойлгох юм бол Бурханы өмнө очиж, Түүнтэй ойр дотно болоход сайн хүн байхаас илүү зүйл шаардлагатай гэдгийг мөн ойлгодог. Гэм нүгэлтэй бид Бурханд таалагдах юу ч хийж чадахгүй. Тиймээс л бидэнд шашинлаг зан үйл биш харин Аврагч хэрэгтэй байдаг юм. Бурхантай харилцаатай болоход маань тусалж чадах цорын ганц нэгэн бол Есүс мөн.**

-Др. К. Эрик Тоеннес

Үл үзэгдэх чуулганд байгаа одоо амьдарч буй гишүүд нь үзэгдэх чуулганы дотор байдаг гэж бид өмнө нь үзсэн. Яг энэ шалтгааны улмаас олон теологичид үзэгдэх чуулганы гадна байгаа хүмүүст аврагдах боломж үгүй гэж үздэг. Өөрөөр хэлбэл энэ нь тухайн хүн үзэгдэх чуулганы нэгэн хэсэг биш бол аврагдах ямар ч боломжгүй гэсэн санаа юм.

МЭ 200-258 оны хооронд амьдарч байсан анхны чуулганы эцэг Киприан Чуулганы нэгдлийн талаарх номдоо энэ тухай өгүүлдэг. Тэрээр:

**"Чуулганаас салж, завхай явдалтай нэгдсэн хүн Чуулганд өгсөн амлалтыг ч бас алдана. Христийн Чуулганд ирдэггүй хүн Христийн өгөх шагналыг ч авч чадахгүй. Тэр хүнийг үл таних, гаднын дайсан гэж үзнэ. Бурхан түүний эцэг биш, чуулган түүний эх биш" гэжээ.**

Энд Киприан үзэгдэх чуулганыг орхисон хүмүүсийн тухай маргасан байна. Түүний гол санаа бол үзэгдэх чуулганы нэгэн хэсэг биш бол үл үзэгдэх чуулганы нэгэн хэсэг болж, Христийн өгөх шагналыг авч чадахгүй гэжээ. Түүний энэ санаа үзэгдэх чуулган нь Бурхантай гэрээ байгуулсан тухай бидний өмнө үзсэнтэй мөн тохирч байна.

Үнэн хэрэгтээ аврал бол Бурханы гэрээний ерөөл юм. Бид энэ тухай Иеремиа 31:31-34, Лук 1:69-75, Ром 11:27, Еврей 7:22-25 гээд өөр олон эшлэлээс харж болно. Нэг жишээ болгон Лук 22:20-р эшлэлд Эзэний зоогийн талаар Есүс юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

"Энэ аягатай бол та нарын төлөө урсах Миний цусаар тогтоогдох шинэ гэрээ юм" гэжээ (Лук 22:20).

Есүс баригдсан тэр орой бидний гэм нүглийн золиос болгон урсгах цус нь гэрээ юм гэдгийг хэлсэн. Өөрөөр хэлбэл Христийн цусан дахь аврал зөвхөн Түүний гэрээгээр л дамжин ирнэ.

Бурхан үзэгдэх чуулгантай гэрээ байгуулсан тул аврал нь үзэгдэх чуулганаар дамжин ирнэ гэсэн үг. Үзэгдэх чуулганы хүмүүс итгэлд ирэх үед, эсвэл үзэгдэх чуулган Сайнмэдээгээр дамжуулан итгэгчидтэй болоход энэ нь боломжтой болдог. Мэдээж заримдаа хүмүүс чуулганы ямар ч оролцоогүйгээр аврагддаг. Гэхдээ тэр тохиолдолд ямар нэгэн ер бусын онцгой тохиолдол байдаг гэдгийг ойлгох нь чухал.

Үл үзэгдэх чуулган нь даян дэлхийн чанартай учраас Бурханы гэрээнд итгэмжтэй байсан хүмүүс л аврагдана. Өөр шашны хүмүүс шашныхаа сургаалыг дагаж, хэчнээн сайн ёс зүйтэй байсан ч тэнгэрийн улсад очих найдвар тэдэнд үгүй. Бид Сайнмэдээ тараах ёстой. Бид хүмүүст цорын ганц Аврагчийн тухай хэлэх ёстой. Бид тэднийг гэрээний харилцаанд, газар дэлхий дээрх Бурханы хаанчлалд авчрах ёстой. Тэгээд бид тэдэнд уг хаанчлалын Эзэн ба Хааныг хайрлан дагахыг зааж өгөх ёстой. Үл үзэгдэх чуулганы даяар чанар бол аврагдсан хүн бүрийн хувьд агуу их урам зориг юм. Энэ бол бидний Христ доторх нэгэн ижил хүсэл тэмүүлэл мөн. Харин Христ дээр хараахан ирээгүй байгаа хүмүүсийн хувьд энэ бол аймшигт анхааруулга юм.

Ингээд чуулганы талаарх хичээлээрээ бид чуулганы хүлээн зөвшөөрөл болон чуулган нь ариун бөгөөд даяар буюу даян дэлхийн чанартай гэдэг тухай үзлээ. Одоо харин бид дараагийн том сэдэв уруу ороход бэлэн боллоо. Энэ бол Чуулган нь ариун хүмүүсийн нэгдэл гэдэг тухай юм.

## НЭГДЭЛ

---

Бид "Ариун" гэдэг үгийн тухай үзэхдээ "ариун хүмүүс" гэдэг үгийг ерөнхийд нь үзэгдэх чуулганд байгаа хүн бүрийг, ялангуяа үл үзэгдэх чуулганд байгаа хүн бүрийг хэлдэг гэж үзсэн. Тиймээс бид ариун хүмүүсийн нэгдлийн тухай ярихдаа бидний хараахан судалж амжаагүй байгаа нэгдэл гэдэг үгэнд гол анхаарлаа хандуулах болно.

Элч нарын тунхгийн эртний Грек хэл дээрх хувилбарт нэгдэл гэдэг үгийг койнониа (κοινωνία) гэсэн байдаг. Бичвэрт энэ үгийг чуулганы гишүүдийн хооронд буй, ялангуяа Бурхантай нэгдэх замаар бий болсон тэрхүү нөхөрлөлийг илэрхийлэхийн тулд ихэвчлэн ашигладаг. Үйлс 2:42, 2 Коринт 13:14, 1 Иохан 1:3 зэрэг эшлэлүүдээс үүнийг харж болно.

Шинэ Гэрээнд койнониа гэдэг үгээр эд зүйлс, мөнгө төгрөг хуваалцах гэсэн утгыг бас илэрхийлсэн байдаг. Ром 15:16, 2 Коринт 9:13, мөн Еврей 13:16-р эшлэлүүдээс бид үүнийг харж болно. Мөн Сайнмэдээг хуваалцах гэдгийг илэрхийлэхдээ энэхүү үгийг ашигласан байдаг. Энэ нь хүмүүст сайнмэдээ тараах гэдэг утгаараа биш, харин Филиппой 1:5, Филемон 6-р эшлэлд бичсэнчлэн чуулган дотор буй хүмүүс нь Сайнмэдээг хуваалцагчид болсон тухай байдаг.

Яг энэ утгаараа "нэгдэл" гэдэг үгийг тунхагт уламжлал ёсоор чуулганы гишүүдийн нөхөрлөл буюу бидний нийтээр эзэмшин хуваалцдаг зүйлс, хуваалцдаг хүмүүстэйгээ харилцан хамааралтай байх гэсэн утгаар ашигласан.

Ариун хүмүүсийн нэгдлийн тухай судлахдаа бид одоогоор тодорхой байгаа ялгааны хүрээнд голчлон ярилцах болно. Эхлээд бид үзэгдэх чуулганы дотор оршдог нэгдлийн тухай үзнэ. Дараа нь, үл үзэгдэх чуулганы доторх нэгдлийн тухай судална. Ингээд үзэгдэх чуулганы доторх ариун хүмүүсийн нэгдлийг тухай эхлээд үзье.

## Үзэгдэх чуулган

Үзэгдэх чуулганы дотор байдаг нэгдэл олон талтай ч гурван талыг нь л хамтдаа авч үзье. Нэгдүгээрт, нигүүлслийн арга замууд. Хоёрдугаарт, сүнслэг бэлгүүд. Гуравдугаарт материаллаг зүйлс. Тэгэхээр эхлээд нигүүлслийн арга замуудын тухай ярилцъя.

## Нигүүлслийн арга замууд

Нигүүлслийн арга зам гэдгийг Бурхан Өөрийн хүмүүст нигүүлслээ өгдөг хэрэгсэл эсвэл механизм гэж хэлж болно. Методист Чуулганы үндэслэгчдийн нэг Жон Весли нигүүлслийн арга замыг Христитгэлийн олон янзын уламжлалын үүднээс тайлбарласан байдаг. Түүний Малахи 3:7 дээр тулгуурлан бичсэн 16-р номлолдоо юу гэж бичсэнийг сонсоцгооё. Энд:

**"Нигүүлслийн арга зам" гэдгийг би Бурханы тогтоосон гадаад тэмдэг, үг, үйлдэл гэж ойлгодог. Энэ нь хүмүүсийг сэргийлэх, зөвтгөх, ариусгах нигүүлслээ урсгах төгсгөлийн төлөө тогтоогдсон суваг юм" гэжээ.**

**Нигүүлслийн арга замыг зарим хүмүүс хаанаас гаралтайгаасаа шалтгаалан сүнслэг сахилгажуулалт эсвэл итгэлийн үйлс гэж тодорхойлдог. "Тэд үүнийг хэрхэн үйлддэг вэ?" гэхийг сонсоод би "Тэд хийгээгүй, харин Бурхан хийсэн, Бурханы нигүүлсэл л энэ бүхнийг хийсэн" гэж би хариулмаар байдаг. Гэхдээ нигүүлслийн арга зам нь бидэнд нигүүлслийг хүлээн авах, ашиглах боломжийг**

**өгдөг. Мөн бидний амьдрал дахь Бурханы нигүүлсэлд анхаарлаа хандуулах хугацаа ба орон зайг бий болгож өгдөг. Би үүнийг усны хоолойтой зүйрлэмээр байна. Ус, хоолой хоёрын ач холбогдлыг бид андуурч болохгүй. Амийг тэтгэх тэр усыг бид хүсэж байгаа. Харин ус тэр хоолойгоор урсаж ирнэ шүү дээ. Тэгээд бид усыг уух боломжтой болно. Яг үүнтэй адил нигүүлслийн арга зам бидэнд амийн усыг уух боломжийг олгодог.**

**-Др. Стив Харпер**

Тодруулж хэлбэл Бурхан бидэнд нигүүлслээ үзүүлдэг олон арга зам байдаг. Зовлон бэрхшээл, итгэл, сайн үйлс, нөхөрлөл гээд л. Гэхдээ теологичид нигүүлсэл бидэнд ирдэг онцгой гурван арга замыг онцолдог. Эдгээр нь Бурханы үг, баптисм ба Эзэний зоогийн ёслол, мөн залбирал гэсэн гурван арга зам юм. Энэ гурван нигүүлслийн арга зам гурвуулаа үзэгдэх чуулганы итгэдэг, итгэдэггүй бүх хүнд хамаатай.

Вестминстрийн Богино Асуулт хариулт болох Христитгэлийн сургаалын уламжлалт Протестант хураангуйн 88-р асуулт хариулт дээр нигүүлслийн арга замын тухай тайлбарласан байдаг. Энд:

**"Асуулт: Христ бидэнд авралын ашиг тусыг өгдөг гадна харагдах арга замууд юу вэ?"**

**Хариулт: Христ бидэнд авралын ашиг тусыг өгдөг гадна харагдах болон ердийн арга замууд бол Түүний ёслол зан үйлс юм. Ялангуяа үүнд Түүний үг, ариун ёслолууд ба залбирал орно. Энэ бүхэн нь сонгогдсон хүмүүст авралын төлөө хэрэгждэг" гэжээ.**

Ром 10:14, 1 Коринт 10:17, мөн 1 Петр 3:12,21 зэрэг эшлэлүүд дээр эдгээр нигүүлслийн арга замуудын ашиг тусын тухай бичсэн байдаг.

Одоо авралын ашиг тус мэдээж үл үзэгдэх чуулганы хувьд аврагдсан хүмүүст хамаатай бол, ёслол зан үйл нь үзэгдэх чуулганы хувьд бүх хүнд хамаатай. Үл үзэгдэх чуулган харагдахгүй гэдгийг бүү мартаарай. Тэнд хэн байгааг бид мэдэхгүй. Үл үзэгдэх чуулганд магтаал хүндэтгэлийн цуглаан болдоггүй, үйлчлэл байхгүй. Чуулганы засаглал гэж байхгүй. Эдгээр нь зөвхөн үзэгдэх чуулганд л өгөгдсөн. Яг үүнтэй адил нигүүлслийн арга замууд болох номлол, баптисм ба Эзэний зоогийн ёслол мөн залбирал зэргийг хүмүүс хараад таньдаг. Тэд нүдэнд харагдахуйц байдаг. Эдгээр нь үзэгдэх чуулганы нийтээрээ хуваалцан үйлддэг зүйлс тул үзэгдэх чуулганы нэгдлийн салшгүй хэсэг билээ.

Нигүүлслийн арга замууд нь Бурхан бидний амьдралд авралын ерөөлүүдээ өгөхийн тулд ашигладаг чухал арга хэрэгсэл байсаар ирсэн. Тиймээс бид тэдгээрийг бүрэн дүүрнээр ашиглах ёстой. Бид Сайнмэдээг түгээж бусдыг итгэл дээр авчрах ёстой. Үгийг номлон мэргэн ухаан болон төлөвшлийг авчрах ёстой. Сайнмэдээг танилцуулж, Бурханы гэрээнд нэгтгэдэг ариун ёслолуудыг бид хамтдаа тэмдэглэж байх ёстой. Бид Бурханы нигүүлсэл, уучлал, өөрчлөлт болон төлөвшлийн төлөө залбирч, гэм нүглийг эсэргүүцэн, ёрын муугаас хамгаалж, хэрэгцээт үед маань авран

хамгаалахын төлөө залбиран гуйж байх ёстой. Эдгээр болон өөр олон шалтгаанаар нигүүлслийн арга замууд бол үзэгдэх чуулганы үнэ цэнтэй үйлчлэлүүд юм шүү дээ.

Нигүүлслийн арга замуудаас гадна үзэгдэх чуулган нь мөн сүнслэг бэлгүүдтэй байдаг.

## Сүнслэг бэлгүүд

Тэгэхээр сүнслэг бэлгүүд үзэгдэх чуулганд бүхэлд нь хамаатай гэдэг нь үзэгдэх чуулганы хүн бүр Ариун Сүнстэй гэсэн үг биш гэдгийг бид ойлгох нь чухал. Тийм биш ээ. Зөвхөн итгэгчдийн дотор л Ариун Сүнс оршдог. Хэдий тийм ч Ариун Сүнс нь бэлгүүдийг үзэгдэх чуулганыг босгон байгуулах зорилгоор ашигладаг. Зарим хүмүүсийн хувьд энэ нь ариусал болон төлөвшилд өсөх тухай байдаг. Мөн заримынх нь хувьд тэднийг итгэлд авчрах гэсэг утгатай байна. Гэхдээ аль ч тохиолдолд үзэгдэх чуулганд байгаа хүн бүр сүнслэг бэлэг авьяасыг харж мэдэрч, ямар нэг хэмжээгээр оролцох ч боломжтой байдаг. Тийм учраас сүнслэг бэлэг авьяасуудыг үзэгдэх чуулган бүхэлдээ хуваалцан ашигладаг гэж хэлэх нь зүйтэй.

Сүнслэг бэлгүүдийг үзэгдэх чуулган бүхэлдээ хуваалцан ашигладаг гэдгийг хэд хэдэн янзаар тайлбарлаж болно. Нэгдүгээрт, бэлгүүдийг нийтийн мөргөлийн үйлчлэлд ашигладаг. 1 Коринт 14:13-26-р эшлэл дээр энэ тухай тодорхой бичсэн байдаг. Хоёрдугаарт, бэлгүүдийн гол зорилго бол чуулганыг бүхэлд нь босгон байгуулах явдал юм. 1 Коринт 12:4-7, Ефес 4:3-13 зэрэг эшлэлүүдээс бид энэ тухай харж болно. Гуравдугаарт, 1 Коринт 14:21, 22-р эшлэлд Паул хэлнүүдийг чуулган дахь итгэдэггүй хүмүүст хүртэл зориулсан шинж тэмдэг гэж онцлон хэлсэн байдаг. Дөрөвдүгээрт, Еврей 6:4-6-р эшлэлд үл итгэгчид сүнслэг бэлгийн ашиг тусыг хүртэж чадахгүй бол буруутгагдана гэсэн байдаг. Тэгэхээр чуулган дахь сүнслэг бэлгүүдийг итгэдэг, итгэдэггүй бүх хүн адилхан хуваалцаж, ашигладаг гэдгийг Бичвэрт тодорхой хэлсэн байна.

Нигүүлслийн арга замуудын адил сүнслэг бэлгүүд бас орчин цагийн үзэгдэх чуулганд их ач холбогдолтой. Үнэнийг тунхаглаж, төөрөгсдийг эргүүлэхэд сүнслэг бэлгүүд нь тун хэрэгтэй байдаг. Итгэгчид итгэлээр өсөж, төлөвшихөд сүнслэг бэлгүүд тусалдаг. Өршөөл, зочломтгой байдал гэх мэт бэлгүүд нь Бурханы хүмүүсийн газар дэлхий дээрх хэрэгцээг хангахад маш чухал үүрэгтэй. Ариун Сүнс хүмүүстээ бэлгүүдийг өгсөн л бол бид тэдгээрийг үзэгдэх чуулганы хэнээс ч харамлахгүй, бүх хүний төлөө ашиглахыг урамшуулан дэмжих учиртай.

Үзэгдэх чуулганы нэгдэл нь чуулганы хүмүүс бие биетэйгээ байгаа зүйлсээ хуваалцахад оршиж байдаг.

## Материаллаг зүйлс

Нэгдэл буюу койнониа нь (κοινωνία) Библид болон анхны чуулганы үед Христитгэгчид байгаа бүхнээ үзэгдэх чуулганы хэрэгцээтэй хүн бүртэй хуваалцах гэдэг утгыг ч бас илэрхийлдэг. Ром 15:26, 2 Коринт 8:4, 9:138 мөн Еврей 13:16 зэрэг эшлэлд бичсэнээр бол Койнониа (κοινωνία) гэдэг үгээр ихэвчлэн ядууст туслахыг бас илэрхийлсэн байдаг.

Койнониа (κοινωνία) гэдэг үгийг ашиглаагүй байсан ч анхны итгэгчдийн амьдралаас нэгдлийн энэ талыг бид үргэлж хардаг. Жишээ нь, анхны олон олон Христитгэгчид эд хөрөнгөө зарж, чуулганд хандив өгдөг байсныг бид Үйлс 2:44-45, 4:34-35 зэрэг эшлэлээс хардаг. Анхны чуулганы үед зарим баатарлаг итгэгчид бусдыг чөлөөлөх эсвэл ядууст туслахын тулд өөрсдийгөө боол болгон зарж байсан.

МЭ 30-100 онд амьдарч байсан анхны чуулганы эцэг Клемент энэ тухай 1 Клемент гэдэг Коринтчуудад хандсан захидалдаа бичсэн байдаг. Тэрээр захидлынхаа 55-р бүлэгтээ:

**"Бидний дундах олон хүн бусдыг чөлөөлөхийн төлөө өөрсдийгөө боол болгон зарсныг бид мэднэ. Олон хүн бас өөрсдийгөө боол болгон зарж олсон мөнгөөрөө ядууст тусалсан" гэжээ.**

Анхны чуулганы үед нэгдэл гэдэг маш хүчтэй байсан тул итгэгчид бусдын хэрэгцээг өөрсдийнхөөсөө ч дээгүүр тавьдаг байсан. Тэд байгаа бүхнээ хуваалцаад зогсохгүй эрх чөлөөгөө хүртэл золиослон, бусдад өгөхийг хүсдэг байсан. 2 Коринт 8:3-5-р эшлэл дэх Паулын үг тэдний бодол санааг ойлгоход тусалдаг. Тэрээр энд:

"Учир нь тэд хэр чадлаараа болон хэрээсээ ч илүү, сайн дураараа өгснийг би гэрчилнэ. Ариун хүмүүсийн төлөөх үйлчлэлд оролцох ивээлийн талаар биднээс асар шаргуугаар гуйж...харин тэд өөрсдийгөө эхлээд Эзэнд, дараа нь Бурханы хүслийн дагуу бидэнд өгсөн" гэжээ (2 Коринт 8:3-5).

Энэ эшлэлд Паул Македоны чуулганыхны өгөөмөр байдлыг дүрсэлжээ. Тэд Эзэнд үнэнчээр бүхнээ зориулж байсан учраас Эзэний үзэгдэх чуулганы төлөө ч мөн тийнхүү золиослон зориулсан гэж тайлбарласан байна.

Хэрэгцээтэй нэгэнтэйгээ байгаа эд зүйлсээ хуваалцах нь үзэгдэх чуулганы амьдралын салшгүй хэсэг мөн. Чуулган бүхэлдээ Бурханы хүмүүс, гэрээний ард түмэн юм. Бурхан чуулганыхаа хүн бүрийг анхаардаг. Мөн бие биеэ анхаарахыг биднээс хүсдэг. Тодруулбал бидний бүх зүйл Эзэнийх шүү дээ. Харин Тэр бидэнд Өөрийн зүйлсийг нярав байхаар хариуцуулсан юм. Тэгэхээр бид хүмүүст тусалж, өглөг хандив өгөх нь Эзэн Өөрийн хүмүүст үйлчилж буй хэрэг бөгөөд дэлхийд Түүний Сайнмэдээг гэрчилж буй явдал юм. Тиймээс хэрэв бид Түүнд итгэмжтэй байа гэвэл ямар нэг зүйл хэрэгтэй байгаа Түүний хүмүүсээс харамлаж болохгүй билээ.

Ингээд бүгдээрээ үзэгдэх чуулганы ариун хүмүүсийн нэгдлийн тухай үзлээ. Тэгэхээр одоо үл үзэгдэх чуулганы ариун хүмүүсийн нэгдлийн тухай үзэхэд бэлэн болжээ.

## Үл үзэгдэх чуулган

Бид үл үзэгдэх чуулган дахь ариун хүмүүсийн нэгдлийн талаарх хоёр гол санааг авч үзэх болно. Эхлээд бид бүх итгэгчдийн Христтэй нэгдсэн нэгдлийн тухай ярилцана. Харин дараа нь үл үзэгдэх чуулганд итгэгчид өөр хоорондоо нэгдмэл

байдаг тухай бид үзэх болно. Ингээд хамтдаа бидний Христтэй нэгдсэн нэгдлийн тухай эхлээд ярилцъя.

## **Христтэй нэгдсэн нэгдэл**

Христитгэгчид Христтэй нэгдсэн байдаг тухай Шинэ Гэрээнд цөөнгүй дурдсан байдаг. Гэхдээ энэ санаагаа ихэвчлэн "Христийн дотор" эсвэл "Есүсийн дотор", мөн "Түүний дотор" гэсэн үгээр илэрхийлсэн байдаг. Нэг талаас энэхүү нэгдэл нь Есүс Өөрийн үхэл ба амиллаараа Эцэгийн өмнө биднийг төлөөлдөг гэсэн үг. Харин нөгөө талаас итгэгчид ямар нэг нууцлаг байдлаар Есүстэй нэгдсэн гэсэн үг. Есүс итгэгчдийн дотор, харин итгэгчид Түүний дотор оршин байдаг.

**Бид Есүс Христтэй нэгдсэн, бид Түүнийх гэдэг санаа бол Паулын гол сургаал номлолуудын нэг юм. Библийн илчлэлүүдийг бүхэлд нь авч үзвэл биднийг нэг бол Адамын дотор эсвэл Христийн дотор байгаа гэж заасан байдаг. Мэдээж Адам бол анхны хүн. Бүх хүн төрөлхтөн түүний хөвгүүд, охид гэсэн үг. Тиймээс ч хүн бүр төрөхдөө л гэм нүгэлтэй төрдөг. Энэ нь хүмүүний уг гарал гэм нүгэлтэй, Бурханаас холдсон гэсэн үг юм. Христэд итгэж, аврагдаж, чөлөөлөгдөнө гэдэг нь Христтэй нэгдэж, Христийнх болно гэсэн үг. Христтэй нэгдэнэ гэдэг нь Түүний бодгалийн нэгэн хэсэг болно гэсэн үг юм.**

**-Др. Томас Р. Шрайнер**

**Бид Христтэй нэгдэж байж л Христийн ач тусыг хүлээн авах боломжтой болно. Түүхэн талаас нь авч үзвэл тэдгээр ач тус нь зөвтгөл, ариусгал, Бурханы хүүхдүүд болох нь юм. Өөрөөр хэлбэл Авралын дотор бидний хүлээж авч болох бүгд багтана. Гэвч тэдгээрийг зөвхөн Христийн дотор хүлээж авна. Тиймээс Христтэй нэгдэж эдгээр үр ашгийг хүлээн авах нь бидэнд маш чухал, хамгийн чухал нь мөн. Тэгвэл бид хэрхэн тэдгээр ашиг тусыг хүртэж, хэрхэн Христтэй нэгддэг вэ? Итгэлээр, зөвхөн итгэлээр л нэгддэг. Зөвхөн итгэл л биднийг Христтэй нэгдэх нэгдэл болон Бурханы бидэнд өгдөг итгэлийн бэлгүүд рүү хөтлөн дагуулдаг юм шүү дээ.**

**-Др. Жеффри К. Жүе**

Есүс болон итгэгчдийн энэхүү нэгдлийг хэрхэн бий болдгийг Библид тодорхой тайлбарлаагүй тул теологичид их л нууцлаг мэтээр ярьдаг. Гэвч бид бие махбод ба сүнсээрээ аль алианаар нь нэгддэг гэдгийг Библид тодорхой хэлсэн байдаг. Иохан 15:4-7, Ром 8:9-11 зэрэг олон эшлэлээс бид энэ тухай харж болно. Жишээ болгож 1 Коринт 6:15-17-р эшлэлд Паул юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:



"Биес чинь Христийн эрхтнүүд гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? ... Харин Эзэнтэй нийлсэн нь Түүнтэй нэг сүнс болой" гэжээ (1 Коринт 6:15-17).

1892 оны хооронд амьдарч байсан алдарт Баптист номлогч Чарлес Спёржеон "Хосгүй Нууц" хэмээх номлолдоо Ефес 5:30-р эшлэлд үндэслэн Христтэй нэгдсэн нэгдлийн тухай ийнхүү дурдсан байдаг. Тэрээр хэлэхдээ:

**"Христ ба бидний хооронд чухал нэгдэл бий... Энэ бол эв нэгдэл төдий биш. Энэ бол адил болсон гэсэн үг. Энэ бол зүгээр нэг нийлэхээс илүү нэгэн бие, нэгэн биеийн салшгүй хэсэг болсон гэсэн үг... Христ... Өөрийн хүмүүсийг авах ёстой. Тэд Түүнд чухал юм" гэжээ.**

Бидний Христтэй нэгдсэн нэгдэл нь үнэхээр чухал байдаг нь гайхалтай. Энэ нь бид Христээс салгагдвал Христэд Өөрт нь маш том алдагдал болохоор хэмжээний тийм чухал. Тэр бидэнд хайртай тул бидний төлөө амиа өгсөн. Тийнхүү бид Түүний шагнал, Түүний өв болдог. Түүнтэй нэгдсэн учраас итгэгч бүр авралдаа агуу их амар тайвныг мэдэрч, өршөөгдсөн гэдэгтээ агуу гайхалтай баталгааг авч, Бурханы өмнө зөвт байх агуу том урам зоригийг олж авдаг. Бид энэ нэгдлээс хүч чадлыг авч, Христээр тэтгэгдэж, Ариун Сүнсээр батжих ёстой. Бид Христийн дотор халхлагдаж Эцэг, Хүү, Ариун Сүнсний өмнө төгс болсон учраас Бурхантай нөхөрлөсөн нөхөрлөлдөө бас итгэл төгс байх ёстой. Гэхдээ энэ нь Бурхан биднийг сахилгажуулахгүй гэсэн үг биш. Харин биднийг хайраар сахилгажуулж, биднийг төлөвшүүлж, Бурхантай үүрд мөнх нэгдэхэд тохиромжтой төгс төгөлдөр болгоно гэсэн үг.

Бид итгэгчид Христтэй нэгдмэл байдаг тухай үзлээ. Тэгэхээр одоо бид Христийн дотор итгэгчид хоорондоо нэгдмэл байдаг тухай харах болно.

## **Итгэгчдийн нэгдэл**

Үл үзэгдэх чуулган дахь хүн бүр Христтэй нэгдмэл учраас итгэгчид бас бие биетэйгээ нэгдмэл юм. Ром 12:5, Галат 3:26-28, Ефес 4:25 зэрэг олон эшлэлд энэ тухай бичсэн байдаг. Иохан 17:22-23-р эшлэлд Есүс Эцэгтээ хандан энэ нэгдлийн тухай юу гэж хэлснийг сонсоцгооё. Энэ нь:

"Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Надад өгсөн сүр жавхланг тань Би тэдэнд өгсөн билээ. Би тэдний дотор, Та Миний дотор. Ингэснээр тэд бүрэн төгс нэг болж, Та Намайг илгээсэн, Намайг хайрласны адилаар тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно" гэжээ (Иохан 17:22-23).

Бидний үзэгдэх чуулгантай нэгдсэн нэгдэл маань харилцаа ба туршлага төвтэй. Харин бидний үл үзэгдэх чуулгантай нэгдсэн нэгдэл нь сүнслэг бөгөөд оршихуйтай холбоотой байдаг. Бид бүхий л талаараа Христ болон Түүний Сүнсээр дамжуулан салшгүй холбоотой болсон. Үүний үр дүнд бид бүгд Христ дотор адил

байр суурьтай болсон хэмээн 2 Коринт 5:14-16, Галат 3:28, мөн Колоссай 3:11-т Паул бичсэн байдаг. Мөн бид бие биеийнхээ баяр хөөр, зовлон шаналлыг хуваалцдаг гэж 1 Коринт 12:26-р эшлэлд өгүүлдэг.

Үл үзэгдэх чуулганы нэгдэл нь газар дэлхий дээрх чуулганаар хязгаарлагддаггүй. Харин тэнгэр дэх чуулганыг хамруулж, аль хэдийн нас барж, Эзэнтэй хамт байгаа итгэгчдийг хүртэл багтаадаг. Газар дэлхий дээрх итгэгчид нь Христээр болон Христ дотор бие биетэйгээ нууцлаг байдлаар нэгдсэн байдгийн адил газарт төдийгүй тэнгэрт буй итгэгчдийг оруулаад Христтэй нэгдсэн хүн бүрд үүний адил нэгдэл бий. Библийн Еврей 11:14 болон 12:22-24-р эшлэлд энэ тухай заасан байдаг.

Энэ үнэнийг тайлбарлахын тул Библид ашигласан нэгэн гайхалтай зүйрлэл бол Христийн сүйт бүсгүйн дүр зураг юм. Энэ нь үзэгдэх чуулганыг Христийн сүйт бүсгүйтэй адилтгасан байдаг. Гэхдээ энэ нь үл үзэгдэх чуулган дахь төгс төгөлдөр сүйт бүсгүй гэсэн үзэл санааг байнга агуулсан байдаг. Хуучин Гэрээнээс бид Исаиа 54:5-8, Хосеа 2:19-20, мөн Ефес 5:26-27 зэрэг эшлэлээс энэ тухай олж хардаг. Харин Илчлэл 19-р бүлэг дэх төгс төгөлдөр болсон үл үзэгдэх чуулганаас бид энэ дүр зургийн биеллийг олж хардаг.

Илчлэл 19:6-8-р эшлэл дэх Иоханы үзсэн үзэгдлийн талаарх тэмдэглэлийг сонсоцгооё. Энд:

"Хурсан олны дуу шиг, их усны шуугиан мэт, хүчит аянгийн нүргээн адил дуу гарахыг би сонсов. Халлелуяа! Төгс хүчит Эзэн Бурхан маань хаанчилж байна. Баярлан хөөрч, Түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөөе. Учир нь Хурганы хурим болж, Сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэр, нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь нарийн маалинга нь Ариун хүмүүсийн зөвт үйлс юм гэв" (Илчлэл 19:6-8).

Энд Христийн сүйт бүсгүй гэдгээр бүх цаг үеийн аврагдсан ариун хүмүүсийг хэлжээ. Бид бүгд нэгэн бие болж, итгэгч бүрийн зөвт үйлсээр урласан нэг хуримын өмсгөлийг өмсөх болно.

Библи итгэгчид нь Христийн дотор бие биетэйгээ нэгдсэн гэдэг үнэнд үндэслэн олон зүйлийг бидэнд зааж сургасан байдаг. Энэ үнэн бидэнд итгэгч бүр үнэ цэнтэй, Христийн хувьд юугаар ч сольшгүй чухал гэдгийг зааж өгдөг. Энэ нь биднийг бие биеэ хүндэлж, бие биедээ үйлчлэхийг заадаг. Мөн биднийг бие биедээ өрөвч энэрэнгүй, тэвчээртэй бас өршөөнгүй хандаж, эелдэг зөөлөн байхыг заадаг. Энэ нь бидэнд бусад хүмүүс бидэнтэй хэрхэн харьцаасай гэж хүсэж байна тийнхүү бусдад хандахыг заадаг. Учир нь Христээр дамжуулан нэгдсэн бидний энэхүү нэгдэлд бид бие биетэйгээ биеийнхээ нэг хэсэг адил нэгдэн нэг болсон билээ.

## ДҮГНЭЛТ

Элч нарын тунхгийн тухай энэхүү хичээлээр бид чуулганы тухай онолыг судаллаа. Бид чуулганыг Бурханы онцгой ард түмэн болгодог тэнгэрлэг хүлээн

зөвшөөрлийн тухай үзсэн. Мөн чуулган бол тусгаарлагдсан бөгөөд цэвэр ариун юм гэдгийг судалж мэдсэн. Мөн бид чуулганыг католик буюу даяар чанартай болохыг үзсэн. Харин дараа нь бид чуулганыг ариун хүмүүсийн нэгдэл гэдгийг олж мэдлээ.

Орчин цагийн Христитгэгчдийн хувьд мэдээж чуулганы тухай ойлголт Библийн цаг үеэс, тэр ч бүү хэл тунхаг бичигдсэн цаг үеэс ч ихээхэн ялгаатай харагддаг. Гэхдээ чуулганы амьдралын суурь бодит байдал хэзээ ч өөрчлөгдөөгүй. Чуулган бол Бурханы гэрээний ард түмэн хэвээр байгаа. Чуулган нь Сайнмэдээг энэ дэлхийд түгээхээр, энэ дэлхийг газар дээрх Бурханы хаанчлал болгохоор сонгогдсон сав хэвээр байна. Бид буюу чуулган нь Эзэнд ариун юм. Бид Түүний хаанчлал, Түүний ард түмэн, Түүний дотор бие биетэйгээ нэгдсэн хүмүүс юм. Эзэн Өөрөө биднээр дамжуулан ажилласаар байгаа билээ.

---

## ХАМТРАГЧИД

---

**Др. Ван Гэйтон (хөтлөгч)** бол Виллиамс Библийн Институтийн салбарын захирал, дэлхий даяарх өөр олон сургалт болон их сургуулиудад Библийн багш, илтгэгч. Др.Гэйтон нь мөн Холбооны Шоронгийн товчооны эрхлэгчээр 4 жил үйлчилсэн. Мөн Вашингтоны Шашин ба Олон нийтийн бодлогын институтийн захирлуудын зөвлөлд байсан. Др.Гэйтон нь Олон улсын Семинар сургуулийн Теологийн мастер, Логос Библийн Коллежээс Шашны мастер, Христитгэлийн Удирдлагын Их Сургуулийн Библийн философийн доктор, Фэйт теологийн семинарийн Теологийн доктор, Реформэд теологийн семинарын Үйлчлэлийн доктор зэргийг тус тус хамгаалжээ. Мөн тэрээр Апостолик Саксэшинд бишопоор томилогдож байсан. Христийн Биеийн түүхэн нэгдлийг сэргээх зорилготой Христитгэлийн чуулгануудын Олон улсын Коммунитигийн Аркбишопоор үйлчилж байсан.

---

**Dr. J. Ligon Duncan III** is Chancellor and CEO of Reformed Theological Seminary and the John E. Richards Professor of Systematic and Historical Theology.

**Dr. John M. Frame** is Professor Emeritus of Systematic Theology and Philosophy at Reformed Theological Seminary in Orlando, Florida.

**Dr. Steve Harper** is the founding Vice President of the Florida-Dunnam campus of Asbury Theological Seminary in Orlando, FL, and retired Professor of Spiritual Formation and Wesley Studies.

**Dr. Dennis E. Johnson** is Professor Emeritus of Practical Theology at Westminster Seminary California.

**Dr. Jeffrey K. Jue** is Executive Consultant at Westminster Theological Seminary after having served there previously as Provost, Executive Vice President and Professor of Church History.

**Dr. Riad Kassis** is International Director of the International Council for Evangelical Theological Education.

**Dr. Samuel Ling** is Co-founder of China Horizon.

**Dr. R. Albert Mohler, Jr.** is President of The Southern Baptist Theological Seminary.

**Dr. John Oswalt** is the Visiting Distinguished Professor of Old Testament at Asbury Theological Seminary.

**Dr. Thomas R. Schreiner** is the James Buchanan Harrison Professor of New Testament Interpretation and Associate Dean of Scripture and Interpretation at The Southern Baptist Theological Seminary.

**Dr. Mark L. Strauss** is Professor of New Testament at Bethel Seminary, San Diego.

**Dr. K. Erik Thoennes** is Professor of Biblical and Theological Studies at Biola University's Talbot School of Theology and is Chair of the Biblical and Theological Studies Theology Department.

**Rev. Dr. Simon Vibert** is Senior Pastor of Christ Church Virginia Water, England, and the former Vice Principal and Director of the School of Preaching at Wycliffe Hall, Oxford.

**Dr. Donald S. Whitney** is Associate Professor of Biblical Spirituality and the Senior Associate Dean of the School of Theology at The Southern Baptist Theological Seminary.

## ҮГСИЙН ТАЙЛБАР

**Католик-** “даяар буюу бүх нийтийн” гэсэн утгатай нэр томьёо. Элч нарын тунхагт чуулган гэдгийг бүх газрын, бүх цаг үеийн, бүх итгэгчдийг багтаан тайлбарлахад ашигласан үг

**Чуулган-** Бурханы гэрээний хүмүүс, Түүний хүмүүсийн цугларалт, Бурханы хаанчлалын дэлхий дээрх үзэгдэхүйц илрэл

**Ромын Клемент-** (МЭ 30-100 он) нэгдүгээр зуунд Коринтын Христитгэгчдэд илгээсэн нөлөө бүхий захидал болох *I Клементийг* бичсэн анхны сүмийн эцэг, Ромын бишоп

**Киприан-(ойр. 200-258 он)** чуулган нь Бичвэрээс дээгүүр эрх мэдэлтэй байх ёсгүй гэдэг уламжлалт сургаалыг бичсэн гуравдугаар зууны Картежийн бишоп

**Экклесиа/ecclesia/ekklesia-** “цугларалт”, “Бурханы хүмүүс”, “чуулган” гэсэн утгатай Грек үг (галиглал)

**Хагиазо/hagiazo** – “ариусах” гэсэн утгатай Грек үг (галиглал)

**Хагиос/hagios** – “ариун” эсвэл “тусгаар” гэсэн утгатай Грек үг (галиглал)

**Ариун-** ёс суртахууны хувьд цэвэр тунгалаг буюу Бурханы онцгой үйлчлэлд зориулан тусгаарлагдсан гэсэн утгатай үг

**Үл үзэгдэх чуулган-** авралд Христтэй нэгдсэн бүх цаг үеийн, бүх хүмүүс

**Жон Нокс-** (ойр. 1505-1572 он) Шотландад Пресбитериан буюу Шинэчлэгдсэн чуулганыг үндэслэгч, Шотландын шинэчлэгч

**Коинония/koinonia** – Шинэ Гэрээний чуулганыг тодорхойлоход хэрэглэгддэг “нэгдэл” эсвэл “нөхөрлөл” гэсэн утгатай Грек үг (галиглал)

**Кадош/qadosh** – “ариун”, “ариуссан” ба “дагшин” гэсэн утгатай Еврей үг (галиглал)

**Чарлес Спөржеон-** (1834-1892) 19-р зуунд амьдарч байсан Английн пастор ба бичээч бөгөөд түүнийг “Номлогчдын Ханхүү” гэж нэрлэдэг.

**Үзэгдэх чуулган-** Чуулганы цугларалтад тогтмол оролцдог хүмүүс. Тэд Христэд итгэх итгэлээ олны өмнө тунхагладаг ч тэдэнд жинхэнэ авралын итгэл буй эсэх нь тодорхойгүй

**Жон Весли-** (1703-1791) Английн санваартан, теологич, Методист Чуулганыг үндэслэгчдийн нэг

**Вестминстерийн Товч Катехизм буюу асуулт хариулт** – 1647 онд анх хэвлэгдсэн Христитгэлийн сургаалын протестант уламжлалын хураангуй